mminfo.mn Шударга, Шуурхай, Өнгийн мэдээлэл

18 дахь жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,086.386... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2016.05.31. Мягмар. №111 (4481) | ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ | Худалдах үнэ 500 төг

**УЛС ТӨР**

АЖИЛТАЙ ОРЛОГОТОЙ МОНГОЛ ИРГЭД АЖЛАА ТАЙЛАГНАЛАА

**II нүүрт**

**ШУУРХАЙ МЭДЭЭ**

**VII нүүрт**

чухал ХҮН



## Н.МӨНХДАШ: ДАРХАНЫГ ХОЁР ДАХЬ НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ АН ХЭРЭГЖҮҮЛНЭ

**Дэлгэрэнгүй ярилцлагыг IV-V нүүрнээс**

Дугаарын 60 мөр

## Хүүхдүүдээ сайхан баярлуулаарай, гэхдээ...

Ж.ОТГОНМЯГМАР

Дэлхийн бүх хөөрхөн багачууд маргааш хүүхэд насныхаа хамгийн гэгээн, дурсамжтай, сэтгэл догдлон хүлээдэг, аз жаргалтай өдөртэй уулзаж байна. Улаанбаатар хотын хүүхэд багачууд төв талбайдаа цуглан, хотын төв баярын уур амьсгалд дарагдаж, бяцхан үрсийн инээд цалгисан энэ өдөр бяцхан үрсээ баярлуулж болох олон үйл явдал өрнөх нь ээ. Тухайлбал, 500 хүүхэд бишгүүрээр Төрийн шагналт, Ардын жүжигчин, удирдаач, хөгжмийн зохиолч Ц.Намсрайжавын хөгжим "Халуун элгэн нутаг" аялгууг хөгжимдөж, Төрийн соёрхолт, Ардын жүжигчин хөгжмийн зохиолч Н.Жанцанноровын "Монгол аялгуу"-г 500 морин хуурч хүүхэд тоглож сонирхуулах юм байна. Мөн 1000 хүүхэд найрал дуу дуулж, 2000 гаруй хүүхэд уран хөдөлгөөнт гимнастикийн үзүүлбэр сонирхуулна.

**Үргэлжлэл нь III нүүрт**

## БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ ӨРСӨЛДӨГЧДИЙН ХЭН НЬ ХЭН БЭ

Б.ӨНӨРТОГТОХ

З.Энхболд даргын удирдсан парламентын халааг авах 76 эрхэм хэн байх вэ гэдэг их сунгаа эхэлсэн энэ үед хэвлэл мэдээлэл бүр өөр өөрийн өнцгөөр үнэлэлт дүгнэлт өгч байна. "Монголын мэдээ" сонин хотын тойргуудыг тоймлон цуврал нийтлэлээ хүргэхээр шийдэж, энэ удаагийн дугаартаа нийслэлийн хамгийн олон хүн амтай дүүргүүдийн нэг болох Баянзүрх дүүргийг онцолж, тус тойргийн зургаан мандатын төлөө өрсөлдөж буй нэр дэвшигч нэг бүрийг уншигчиддаа танилцуулахыг зорилоо. Сонгогчид илүү их мэдээлэл авч, хэн нь хэн бэ гэдгийг таньдаг, мэддэг байгаасай гэсэн үүднээс бүх намууд болон бие даагчдыг ч нэр ус, албан тушаалтай нь тоймлоё.

### Баянзүрхийн нэр дэвшигчид "чихрийн цуглуулга" шиг юм

Сонгуулийн хуулиар зургаан мандаттай болсон Баянзүрх дүүргийн 49 дүгээр тойрогт УИХ-ын гишүүн Д.Оюунхорол МАН-аас нэр дэвшихээр болжээ.

**Үргэлжлэл нь III нүүрт**

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**



Өдөр +27
Шөнө +9







**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1990.00 | 2002.00 | ФУНТ | 2869.00 | 2950.00 |
| ЕВРО | 2191.00 | 2242.00 | РУБЛЬ | 28.40 | 32.20 |
| ИЕН | 17.81 | 18.22 | ЮАНЬ | 301.00 | 305.00 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 1992.00 | 2003.00 | ФУНТ | 2883.00 | 2952.00 |
| ЕВРО | 2188.00 | 2245.00 | РУБЛЬ | 29.29 | 31.74 |
| ИЕН | 17.77 | 18.25 | ЮАНЬ | 302.30 | 305.60 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## МАН нэр дэвшигчдийнхээ бичиг баримтыг СЕХ-д хүлээлгэж өгчээ

УИХ-ын 2016 оны сонгуульд Монгол Ардын намаас нэр дэвшигчдийн бичиг баримтыг өнөөдөр СЕХ-нд хүлээлгэн өглөө. МАН өнгөрсөн баасан гарагт Бага хурлаа хийж, УИХ-ын сонгуульд сойх гишүүдээ тодруулсан билээ. Тэгвэл холбогдох хуульд заасны дагуу морин цагт нэр дэвшигчдийнхээ материалыг СЕХ-д бүртгүүлж байгаа аж. Энэ үеэр МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ж.Мөнхбат хэлэхдээ “МАН хуулийг дээдэлдэг, хэрэгжүүлдэг үлгэр жишээ намын хувьд 76 нэр дэвшигчийн хувьд ямар нэгэн асуудалгүй. Хуулийн хүрээнд бичиг баримтыг нь эцэслэн бүрдүүлээд СЕХ-д албан ёсоор бүртгүүлж байна. СЕХ хуульд заасан хугацаанд манай нэр дэвшигчдийг бүртгэж, сонгуульд оролцох эрхийг нь нээж өгнө гэдэгт итгэлтэй байна” гэлээ. МАН-ын Бага хурал өнгөрсөн баасан гарагт болж, тойрогт сойх гишүүдээ тодруулсан. Тэгвэл МАН-аас дэвшиж байгаа гишүүдийн 40 гаруй хувь нь залуучууд бол 40 хүртэлх хувь нь шинэ нэр дэвшигчид байгааг ч энэ үеэр онцолж байлаа. Олон нийтийн зүгээс МАН залуучуудад итгэл хүлээлгэж, хариуцлагатай сонголт хийлээ гэсэн эерэг хандлагууд нэлээд гарч буй юм. Мөн өчигдөр орой АН-ынхан СЕХ-д нэр дэвшигчдийнхээ баримтыг хүлээлгэж өгчээ.

mminfo.mn Шударга, Шуурхай, Өнцгой мэдээлэл

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн Э.ЭНХЦЭЦЭГ

*Улсын бүртгэлийн дугаар: 907300528*
*Индекс: 100757*

**Редакцийн хаяг:**
**Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот**

**Харилцах утас, факс: 976-70113551**

**“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.**

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## Ажилтай орлоготой монгол иргэд ажлаа тайлагналаа






Н.БАТЗАЯА

Энд бүх зүйл байна. Ташуу энгэртэй дээл, ээтэн хоншоортой гутал, толгойн хив гоёлоо зүүсэн хатад тэмдэглэлийн дэвтэрт бууж, таван хошуу мал шатрын хөлөгт заларчээ. Шүр сувсан эдлэл, охидын үсний даруулга, жижигхэн авдар, эсгий гутал, арьсан цүнх гээд хэн хүний хараа булаах, “Монголчууд ийм зүйл хийж чаддаг болсон юм уу” гэж дуу алдуулах гар урлалын бүтээгдэхүүн өчигдөр Чингисийн талбайд дэлгэгдлээ. Энэ бол Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Ажилтай орлоготой монгол хүн” хөтөлбөрийн үр дүн аж. Тус хөтөлбөрийн хэрэгжилт болон үр дүнг олон нийтэд танилцуулах, хөдөлмөрийн салбарын үйл ажиллагааг сурталчлах, иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хөдөлмөрийн зах зээлийн мэдээ мэдээллийг иргэдэд хүргэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор энэхүү өдөрлөгийг зохион байгуулсан юм. “Ажилтай орлоготой монгол хүн” хөдөлмөрийн өдөрлөгт Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан болон дүүргүүдийн хөдөлмөрийн хэлтэс, хувийн хөдөлмөрийн бирж, аж ахуйн нэгж, байгууллагууд оролцлоо. Өдөрлөгийг нээж, Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан “Монгол Улсын их дээд сургууль, МСҮТ-ийн төгсөгчдийн хонхны баяр болж байгаа энэ цаг үед хөдөлмөрийн өдөрлөг болж буйгаараа ихээхэн ач холбогдолтой. Энэхүү өдөрлөгт Монгол Улсын Хөдөлмөрийн яамны харьяа агентлагуудаас гадна хувийн хэвшлийн байгууллагууд оролцож байгаа. Энд сул чөлөөтэй 535 ажлын байр зарлагдсан. Тэгэхээр мэргэжлийн боловсролтой, ажил хайж байгаа хүмүүс ажил олгогчидтой уулзаад хөдөлмөрийн зах зээлд гарч ажиллах боломж нээлттэй” гэв. Мөн тэрбээр 35-аас дээш насны иргэдийг ажилтай болгоход цогц арга хэмжээ авах шаардлагатай. Учир нь энэ насны хүмүүс ихэвчлэн мэргэжилгүй эсвэл мэргэжлээрээ ажиллах сонирхолгүй хүмүүс байдаг.

Тиймээс салбар яамнаас мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтыг хөдөлмөрийн хэлтсүүдээрээ дамжуулан өргөн хүрээтэй явуулж байгаа. Мөн мэргэжилтэй болохыг хүссэн 35-аас дээш насныхан Хөдөлмөрийн яамны харьяа МСҮТ-д нас харгалзахгүйгээр суралцах боломжтой. МСҮТ-үүд нь Монгол Улсад эрэлт хэрэгцээтэй 192 мэргэжлээр боловсон хүчин бэлтгэдэг. Тус төвийн төгсөгчдийн 80 гаруй хувь нь ажлын байртай болж чаддаг. Ажилгүй иргэд мэргэжлийнхээ дагуу ажил хайгаад байх шаардлагагүй. Дэлхийн бусад улс орны чиг хандлага мэргэжлийн баримжаагаа өөрчлөх, шинэ мэргэжилтэй болоход чиглэж байна. Манай улсад энэ боломж, боломцоо бүрэн байгаа хэмээн онцолсон. Өдөрлөгийн үеэр АСЕМ-ийн дээд хэмжээний уулзалтад зориулан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд санхүүгийн дэмжлэгт хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлдвэрлэсэн бэлэг дурсгалын зүйлс, бараа бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа дэлгэгдсэн. Мөн сул чөлөөтэй ажлын байрны захиалгын дагуу ажил хайгч иргэд, ажилгүй иргэдийг бүртгэх, ажилд зуучлах үйл ажиллагаа явууллаа. Түүнчлэн томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд ажилгүй иргэд, ажил хайгч иргэдтэй ярилцлага хийх, ажлын байранд бүртгэх, ажилгүй хүмүүс, их дээд сургууль, МСҮТ төгсөгчдөд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгсөн. “Ажилтай орлоготой монгол хүн” үндэсний хөтөлбөр нь хөдөлмөр эрхэлтийг дэмжих, ажлын байр бий болгох бодлогыг зөвхөн хөдөлмөрийн салбарын эрхлэх асуудлын хүрээгээр хязгаарлалгүй, салбар дундын зохицуулалттайгаар үндэсний болон орон нутгийн төвшинд хэрэгжүүлсэн ихээхэн ач холбогдолтой анхны хөтөлбөр аж. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилд чухал ач холбогдолтой шинээр ажлын байр бий болгох, хадгалахад чиглэгдсэн бүтээн байгуулалтын олон ажлыг хэрэгжүүлжээ. Тухайлбал, 2013-2014 онд уул уурхай, эрдэс баялгийн чиглэлээр томоохон 42 үйлдвэр ашиглалтад орсноор тус салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн тоо 2015 оны дөрөвдүгээр улирлын байдлаар 1155 болсон байна. Энэ нь 2012 оны дөрөвдүгээр улиралтай харьцуулахад 67.1 хувиар нэмэгдэн улмаар орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, бүтээн байгуулалтыг дагаж суурьшсан иргэдэд төрийн үйлчилгээ үзүүлэхэд чухал нөлөө үзүүлжээ. Тус хөтөлбөрийн хүрээнд энэ мэтчилэн олон ажил хийгдсэн байна. Өдөрлөгийн үеэр салбар яамны харьяа байгууллагуудын үйл ажиллагаатай танилцлаа.

### С.Чойноров: АСЕМ–ийн зочдод худалдах гар урлалын бүтээгдэхүүнийг шалгаруулна

*/Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, судалгаа, мэдээллийн үндэсний төвийн дарга/*

-Засгийн газраас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлдэг. Энэ хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг. Өнөөдөр уг хөтөлбөрөөс санхүүгийн дэмжлэг авсан иргэд өөрсдийн хийсэн бэлэг дурсгалын зүйлс, бараа бүтээгдэхүүнээрээ үзэсгэлэн гар-гаж байна. Бид энэ үзэсгэлэнд тавигдсан бүтээгдэхүүнээс шалгаруулж, АСЕМ-ийн зочдын байрласан байр, зочид буудлуудад худалдана.

### Ц.Эрдэнэбаатар: Хувийн хэвшилд 60 мянган ажлын байр нэмэгдсэн

*/Монголын ажил олгогчдын нэгдсэн холбооны дэд захирал/*

-Монгол Улсын Засгийн газраас “Ажилтай орлоготой монгол хүн” хөтөлбөрийг баталсан. Энэ хөтөлбөрийн гол зорилго нь хувийн хэвшлийн байгууллагыг дэмжих, ажилгүй иргэдийг ажлын байраар хангах юм. Хэдийгээр улс орон эдийн засгийн хямралтай байгаа боловч хөтөлбөрийн хүрээнд хувийн хэвшилд шинээр 60 мянган ажлын байр бий болсон. цаашид одоо байгаа 60 мянган ажлын байрыг тогтвортой авч үлдэх, хорогдуулахгүй байх бодлогыг авч ажиллавал илүү үр дүнтэй байх болно. Мөн энэ хөтөлбөртэй холбоотойгоор үндэсний зөвлөлөөс таван дэд хөтөлбөр баталсан. Тухайлбал, хувиараа бизнес эрхлэгчдийг хэрхэн дэмжих, малчдад санхүүгийн дэмжлэг олгох, их дээд сургуулийн төгсөгчдөд ажлын байр олгох зэрэг тусгай зорилго бүхий хөтөлбөрүүд бий. Эдгээр хөтөлбөрүүд цаашид тогтвортой хэрэгжвэл хувийн хэвшлүүд шинэ ажлын байртай болох боломж бүрдэж байна. Шинэ ажилд ороход ажил олгогчдоос тавьдаг шаардлага өндөр байна гэсэн гомдол хүмүүсээс ирдэг. Ажил хайгчдаас ирэх гомдлыг хуулийн хүрээнд шийдэхийг эрмэлзэж байгаа. Жишээлбэл, хувь хүний ур чадварыг мэдэхийн тулд туршилтын хугацаагаар ажиллуулдаг. Энэ хугацааг багасгах зэрэг олон арга хэмжээг авч ажиллаж байна.

### Т.Энхмөрөн:1000 ажлын байранд залуусыг бүртгэж байна

*/МЗХ-ны дэргэдэх Залуучуудын хөдөлмөрийн төв биржийн байнгын ажлын мэргэжилтэн/*

-Манай байгууллагад бүртгэлтэй нийт 20 мянган оюутан байдаг. Цагийн ажилд бүртгэлтэй цагийн ажлын дэвтэртэй 1800 гаруй оюутан бий. Байнгын болон цагийн ажилд өдөрт 30-40 хүн, заримдаа 50-60 хүн ирж бүртгүүлдэг. Одоогийн байдлаар манай байгууллагад бүртгэлтэй 1000 ажлын байр байна. Өнөөдрийн хөдөлмөрийн яармагийн хүрээнд 1000 ажлын байранд залуучуудыг бүртгэлээ. Ажил олгогч байгууллагуудын зүгээс ажлын туршлагатай гэдэг шаардлага тавьдаг. Тиймээс бид тухайн байгууллагын шаардлагын дагуу оюутнуудыг ажилд зуучилдаг. Мөн бид оюутан залууст туслах, тэднийг дэмжихийн тулд олон сургалт явуулдаг. Жишээлбэл, долоо хоног бүрийн пүрэв гарагт “Part time” сургалтыг явуулдаг. Байнын ажил хайгчдад зориулж “Open mind” сургалтыг зохион байгуулдаг. Уг сургалт нь байнгын ажил хайгчдад хэрхэн ажлын байртай болох, цаашид хэрхэн амжилттай ажиллах талаар заадаг.

ДУУЛИАНЫ МӨРӨӨР

## Н.Энхбаярын бие муудаж эхэлжээ




Намын байрны гаднаас эхэлсэн МАХН-ын гишүүд дэмжигчид, намын дарга Н.Энхбаяр нарын өлсгөлөн өчигдөр гурав дахь өдрөө СЕХ-ны байрладаг Ялалтын талбайд үргэлжилж байгаа юм. Тэгвэл эх сурвалжийн өгсөн мэдээллээр Н.Энхбаяр өлсгөлөн зарлахаас өмнө эмчийн үзлэгт ороогүйгээс бие нь муудаж энэ сарын 29-нд түргэн тусламж дуудахад хүрсэн аж. Өлсгөлөн зарлаж буй иргэдийг тухайн дүүргийн Эрүүл мэндийн нэгдлээс үзэж, шаардлагатай гэвэл эрүүл мэндийн шалтгаанаар өлсгөлөн зарлахыг хориглох учиртай ч Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн нэгдэл Засаг дарга чиглэл өгөөгүй учраас үзэх боломжгүй гэсэн хариулт өгсөн аж. Харин МАХН-ын гишүүд өлсгөлөн зарлаж байна гэдгээ харьяа дүүргийн Цагдаагийн хэлтэс болон Эрүүл мэндийн төвд хандаж албан бичиг хүргүүлсэн хэмээн мэдэгдэж буй юм. Юутай ч гурав дахь өдрөө үргэлжилж буй өлсгөлөнд хэн ч анхаарал хандуулахгүй байгаа бөгөөд ЦЕГ-аас өнөөдрийг хүртэл ялтай, ялгүй эсэх талаар тодорхойлолт гаргаж өгөөгүй аж. Тэгвэл өнгөрсөн ням гарагт АНУ-ын Конгрессийн төлөөлөгчид УИХ-ын даргатай уулзах үеэрээ МАХН-ын дарга Н.Энхбаярын талаар тодруулжээ. Тодруулбал, Конгрессийн төлөөлөгчдийн танхимын гишүүн Жим Макдормет “Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр авлигалын хэргээр шүүгдээд, дараа нь өршөөлд хамрагдсан. Тэрбээр Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших хүсэлтэй байгаа, үүний тулд намынхаа 17 гишүүний хамтаар өлсгөлөн зарлаад байгаа юм байна. Хөндлөнгөөс харахад ойлгоход бэрх энэ үйл явцын талаар тайлбарлаж өгнө үү” гэв. Улсын Их Хурлын дарга хариулахдаа, энэ бол одоо мөрдөгдөж буй Эрүүгийн хуультай холбоотой. Энэ оны есдүгээр сарын 01-ний өдрөөс бид шинэ Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх юм. Одоогийн Эрүүгийн хуульд хуучин нийгмийн тогтолцооноос үлдсэн зүйл гэвэл хүн ял эдлээд дуусахад, үүний дараа “ялтай тооцох хугацаа” гэдэг тодорхой хугацаа байдаг. МАХН-ын дарга Н.Энхбаяр, нам нь манай намтай хамтарч Засгийн газар байгуулсан. МАХН-ын дарга Н.Энхбаярын хувьд “Намайг уучилсан, мөн Өршөөлийн хууль батлагдсан учраас миний ялтай тооцох хугацаа дууссан” гэдэг байр суурьтай байгаа. Харин цагдаагийн байгууллагын зүгээс “Таны ялтайд тооцох хугацаа дуусаагүй” гэсэн. Ийм л маргаан байгаа. Ирэх сонгуулиар ийм маргаан гарахгүй, учир нь шинээр дагаж мөрдөх Эрүүгийн хуульд “ялтай тооцох хугацаа” гэдэг ойлголтыг байхгүй болгосон. Энэ удаагийн парламентын хийсэн хамгийн том реформ бол 1990 оноос өмнө байсан Эрүүгийн хууль болон хуулийн салбартай холбоотой реформыг бүрэн хийж дуусгасан. “Ялтай тооцох хугацаа” гэдэг ойлголт Сонгуулийн тухай хуульд орсон нь зөв эсэх талаар би хувьдаа бодоод л байгаа. Улсын Их Хурлын гишүүнийг ард түмэн сонгодог болохоос цагдаагийн даргын бичгээр сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах нь буруу гэж бодож байна” хэмээн З.Энхболд дарга хариулжээ.

## ҮЗЭЛ БОДОЛ



# БАЯНЗҮРХ ДҮҮРЭГТ ӨРСӨЛДӨГЧДИЙН ХЭН НЬ ХЭН БЭ



**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Түүний хувьд УИХ-д гурван удаа сууж буй туршлагатай улстөрч. Багш мэргэжилтэй энэ бүсгүй монгол төрийн босго ямар өндөр вэ гэдгийг харуулж, тэр хэрээр нийгэмд үнэлүүлж чадсан юм. Боловсрол, эрүүл мэнд, хүүхэд, эмэгтэйчүүд гээд нийгмийн бүх салбарт анхаарлаа хандуулж ажилладаг, энэ чиглэлийн хууль тогтоомж гаргах талаар туухштай ажиллажээ. Мөн 2014 онд БОНХАЖ-ын сайдаар найман сарын хугацаанд ажиллахдаа Зайсангийн иргэдийн газрыг гэрчилгээтэй болгох, хог хаягдлыг ангилах гэх мэт олон ажлыг хийсэн билээ. Тэгвэл Д.Оюунхорол гишүүнтэй АН-аас УИХ-ын гишүүн, Эрчим хүчний сайд Д.Зоригт тулжээ. Өнгөрсөн жилийн сонгуулиар өрсөлдөгчөөсөө 6000 гаруй хүний санал дутуу атлаа УИХ-д ард түмний саналаар биш шүүхийн шийдвэрээр орж ирсэн хэмээн багагүй шүүмжлүүлсэн энэ эрхэм өнөө жил нутагтаа очих нүүргүй болсон уу, яасан юутай ч Баянзүрхийн тойрогт иржээ. Д.Зоригт гишүүний хувьд хоёр удаа УИХ-д суусан ч бодлогын том шийдвэр гаргаж, том том хуулийн автор болсон гэж хэлэхэд хэцүү. Хувь хүнийхээ талаас харсан ч дуу цөөтэй энэ эрхэм инженер эдийн засагч мэргэжилтэй. "Монгол шуудан" компанийн ТУЗ-ийн дарга гэдгээр нь магад ард түмэн илүү таньдаг ч байж мэдэх юм. Түүнчлэн, сүүлийн үед түүнийг оффшор бүсэд данстай гэх мэдээлэл явж байгаа ч гишүүн үүнийг үгүйсгэсэн билээ. Хоёр том намын улстөрчдийн өмнөөс МАХН-ынхан С. Жаргал гэх эрхмийг сойжээ. Төдийлөн олонд танигдаагүй бөгөөд Хэнтий аймгийн Засаг даргаар ажиллаж байсан гэвэл дунд насныхан илүү мэдэх биз. С.Жаргалыг дагалддаг муухай тодотгол нь олон нам сольсон явдал. Тэрбээр, АН-ын гишүүнээс гарч, ИЗНН-д элсч улмаар 2012 онд ИЗНН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдож байв. Гэсэн ч төд удалгүй мөн л тус намын хаалгыг хааж МАХН-д элсч, улмаар тус намын Гадаад харилцаа хариуцсан нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа улстөрчийн хувьд тогтворгүй, үзэл бодол нь холбирсон сулхан өрсөлдөгч харагдаж байгаа юм. 49 дүгээр тойрогт Тусгаар тогтнол эв нэгдлийн эвслээс МНН-ын дарга О.Бум-Ялагчийг сойжээ. Түүний хувьд маш олон жил улс төр хийж яваа хүн. Германд боловсрол эзэмшсэн, ногоон үзэл баримт-лалтай гэдэг утгаараа тодорхой хэмжээний дэмжигчтэй. Тэр ч утгаараа энэ тойрогт нэр дэвшигчдийн аль алиных нь саналыг хуваах магадлал өндөр нэгэн. Тэгвэл ХҮН-ын бие даагчид энэ тойрогт Хуульзүйн яамны газрын дарга асан О.Алтангэрэл гэх залууг явуулжээ. Долдугаар сарын 1-ний хэрэгт холбогдсон цагдаагийн дарга нарт өмгөөлөл үзүүлж эхэлснээр олны анхааралд өртсөн түүнийг Х.Тэмүүжин сайд байх үедээ тун ч их тоож дэргэдээ зөвлөхөөр ажиллуулж байв. Гэвч, энэ тойрогт нэр дэвшч буй олон жилийн хур туршлагатай улстөрчдийн дэргэд төлөв-шөөгүй нэгэн билээ. Харин 50 дугаар тойрогт МАН-аас УИХ-ын гишүүн Ж.Энх-баярыг сойжээ. Жадамбаа генералын хүү гэдгээр их улс төрд алхаж байсан тэрбээр өнөө хэр сайн аавын нэрээр явж байгаа нь худлаа биш. Ж.Энхбаяр эрхзүйч мэргэжилтэй бөгөөд дандаа хил гаалийн салбарт ажиллаж байгаад УИХ-д 2008 онд хөл тавьжээ. Говь-Алтай аймгаас хоёр удаа дэмжлэг авч сонгогдсон тэрбээр, өнөө жилийн сонгуулиар намын жагсаалтад багтана гэсэн итгэл дүүрэн явсан. Тиймдээ ч тойргоо нэг ч удаа эргээгүй учраас ёстой л төөрсөөр төрөлдөө гэгчээр явж байгаад энэ тойргийн онилчихсон гэхэд хэтийдэхгүй. Батлан хамгаалахын сайд байсан гэдэг утгаараа Баянзүрхийн цэргийн анги, нэгтгэлүүдийн саналыг цуглуулж чадна гэх итгэл дүүрэн яваag нуугаад яахав. Тэгвэл Ж.Энхбаярын өмнөөс АН УИХ-ын гишүүн, Сангийн сайд Б.Болорыг явуулжээ. Гадаад хэргийн дэд сайдаар ажиллаж, Б.Хурцыг эх оронд нь авчрах асуудлаар олны анхааралд өртөж, улмаар Архангай аймагт туршлагатай улстөрч түшиж явсаар гарч ирсэн нэгэн. Тэгвэл энэ удаад мөн л туршлагатай улстөрчид дагаж Баянзүрхийг түшсэн нь энэ. Тэрбээр, улстөрчийн хувиар туршлага багатай ч том фракцийг түшсэн учраас том албан тушаалд морилж, өдгөө Сангийн сайдын албыг хашч явна. Үеийн залуус дундаа боловсролоороо ялгардаг байж болох ч улстөрчийн хувиар түүнд товойх зүйл ховор юм. МАХН-ынхан тус тойрогт улс төр судлаач, доктор, дэд профессор Ч.Өлзийсайхан гэх эмэгтэйг өрсөлдүүлсэн байна. Уул уурхайг дагасан улс орнуудын уналт доройтол, парламентын засаглалтай орны давуу болон сул тал зэрэг олон талаас судалгаа хийдэг түүнийг улс төрийн салбарт чамгүй туршлагатай судлаач хэмээн үнэлдэг. Гэвч улстөрч байх хэмжээнд өөрийгөө боловсруулж чадаагүй аж. Тэгвэл энэ тойрогт ТТ эв нэгдлийн эвслээс Яруу найрагч, сэтгүүлч Ү.Хүрэлбаатар нэр дэвшчээ. Урлаг, спортынхон улс төр сонирхох болсон цуваag үргэлжлүүлж буй түүнийг улстөрч гэж харах эсэх нь баянзүрхчүүдийн сонголт биз ээ. 51 дүгээр тойрогт тэгвэл МАН-аас ҮЦХ-ийн захирал асан, НИТХ-ын төлөөлөгч Б.Саранчимэгийг "сойжээ". "Эко хатагтай" гэдгээр олонд илүү танигдсан Б.Саранчимэг МАН-ын лидер улстөрч эмэгтэйчүүдийн нэг яах аргагүй мөн. ОХУ-ын Цахилгаан техникийн их сургуулийг программист мэргэжлээр төгсчээ. Нийслэлийн НАМЭХ-ны тэргүүн, МАН-ын Бага хурлын гишүүн зэрэг сонгуульт албан тушаалаас гадна НИТХ-ын төлөөлөгчөөр хоёр удаа сонгогдож, түмний итгэлийг алдаагүй яваа улстөрч эмэгтэй. Хэдхэн жилийн өмнө шарилжнаас өөр зүйлгүй байсан нүцгэн талыг өдгөө нийслэлчүүдийн хамгийн очих дуртай цэцэрлэгт хүрээлэн болгож чадсан гэдгээрээ тэр баянзүрхчүүдийн өмнө хийсэн зүйлтэй, хэлэх үгтэй очиж байгаа билээ. АН-ынхан харин энэ тойрогт тун ч сул өрсөлдөгч явуулсан. Тодруулбал, ИЗНН-тай тохирсон тохирооны дагуу Р.Булгамаа гэх бүсгүйг явуулжээ. Р.Булгамаа нь хуульч, эрхзүйч мэргэжилтэй бөгөөд олон жил хуульзүйн салбарт ажилласан туршлагатай. Мөн 2007 онд ИЗНН-ыг сонгож, 2012 оны сонгуулиар Баянзүрх дүүрэгт нэр дэвшин ялагдал хүлээж байсан аж. Тэгвэл энэ удаад даагаа нэхэж буй бололтой. МАХН-ынхан энэ тойрогт Батлан хамгаалахын сайд, УИХ-ын гишүүн Ц.Цолмоныг явуулсан аж. Хоёр бүсгүйн өрсөлдөх тойрог эрхэм сайдад магад сулхан харагдсан ч байж мэдэх. Гэвч нэг сонгосон сонголтоосоо урваагүй яваа энэ хоёр эмэгтэйн хажууд эрхэм сайдтан "жижигхэн" харагдаж буйг нуугаад яахав. Ардчилсан үзэл баримтлалаа албан тушаалын төлөө сольж, МАХН-д урвасан гэдгийг ард түмэн мартаагүй байгаа. Сайдын албан тушаалд очсоны дараа түүнийг тойрсон сайн гэхээс илүү саар мэдээлэл олон гарч байв. Ц.Цолмон нь цахилгааны инженер мэргэжилтэй. Тэрбээр, Болгар, ОХУ-д элчин сайдаар сууж байсан, мөн МҮАН-ын гишүүн байхдаа Барилга хот байгуулалтын сайдаар ажиллаж байсан туршлагатай. Тусгаар тогтнол эв нэгдлийн эвслээс энэ тойрогт "Хатан Тулга" компанийн захирал М.Мөнхцэцэгийг өрсөлдүүлэхээр сонгожээ. Хувийн хэвшлийн салбарт ажиллаж байгаа бөгөөд МНН-ын гишүүн гэдгээс өөр мэдээлэл алга. Харин ХҮН-аас уг тойрогт хүний эрхийн хуульч Ц.Баттуяа гэдэг бүсгүйд итгэл өгсөн байна. Тэрбээр, Польш улсад мэргэжил эзэмшсэн нэгэн бөгөөд ЦЕГ-т хуулийн хэлтсийн мэргэжилтэн, Шүүхийн Ерөнхий зөвлөлд референт, Халх журам Хуульзүйн сургуульд багшаар ажиллаж байжээ. Тэгвэл Эх орончдын нэгдсэн эвслээс тус тойрогт намын дарга Г.Ганбат өөрөө нэр дэвшихээр болсон байна. Уул уурхай, эдийн засаг, хууль эрхзүйн гээд олон чиглэлээр тууштай дуугарч яваа түүнийг хаана сургууль төгссөн, ямар мэргэжил эзэмшсэн талаар тодорхой мэдээлэл ховор. Юутай ч 2012 онд намаа байгуулж, парламентад суудалгүй олон намуудтай хамт тууштай улс төр хийж яваа ч өнөө хэр амжилтад хүрээгүй нэгэн. Баянзүрхийн 52 дугаар тойрогт МАН-аас дүүргийн Засаг дарга асан Б.Батзориг нэр дэвшчээ. Түүнийг баянзүрхчүүд андахгүй мэднэ. Дүүргийн Засаг даргаар ажиллаж байхад хэдэн тэрбумаар нохойны хөшөө босгосон нь түүнийг алдартай болгож байв. Эдийн засагч улс төр судлаач мэргэжилтэй бөгөөд сумоч Д.Батбаярын хөрөнгийг захиран зарцуулах албан тушаал эрхэлж байгаад дүүргийн Засаг дарга болж гэнэт тодорч байжээ. Тэгвэл энэ тойрогт АН-аас Ерөнхий сайд Ч.Сайханбилэг байна. Дүүргийн Засаг даргын дэргэд тэр дэлхийн хэмжээнд бодлого ярьж яваа улстөрч. Түүхийн багш, хуульч мэргэжилтэй бөгөөд Залуучуудын холбооноос ажлын гараагаа эхэлж, улмаар Ерөнхий сайд болтлоо өсч чадсан улстөрч юм. Авлига, албан тушаалын хэргээс хол залуу улстөрч учраас АН түүнд Гүйцэтгэх засаглалын тэргүүн гэх албан тушаалыг өгсөн. Тэр ч итгэлийг нь алдаагүй төдийгүй Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эхлүүлсэн сайд хэмээн үнэлэгдэж байгаа билээ. МАХН-аас нэр дэвшсэн Л.Чулуунбаатар компанийн захирал, хувиараа бизнес эрхлэгч гэдгээс өөр мэдээлэл алга. ТТ эв нэгдлийн эвслээс ч мөн компанийн захирал М.Мөнхтуяа гэх эмэгтэй нэр дэвшчээ. Баянзүрхийн 53, 54 дүгээр тойрогт үнэнийг хэлэхэд өрсөлдөөн гарах уу гэж хэлэхэд бэрх. МАН-аас 53 дугаар тойрогт НИТХ-ын төлөөлөгч Б. Төмөрчулууныг сойжээ. Б.Төмөрчулуун нь химич мэргэжилтэй бөгөөд 1990 оныг хүртэл төрийн байгууллагад ажиллаж, улмаар 1991 оноос "Сэргэн мандалт" компанийг үүсгэн байгуулжээ. Харин 2003 оноос улс төрийн албан тушаал сонирхох болж Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргалж, улмаар 2012 онд НИТХ-ын төлөөлөгч болж байв. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын даргаар ажиллаж байх үеийн таагүй мэдээллүүд өнөө хэр түүнийг дагадаг нь худлаа биш. Тэгвэл энэ тойрогт АН Ж.Батзандан гишүүнийг сойсон байна. Эрхэм гишүүн өмнөх сонгуулиар энэ дүүргээс сонгогдсон. Гэхдээ тойрогтоо юм хийсэн үү гэдэг нь эргэлзээтэй. Улс төр судлаач, эрхзүйч, хуульч мэргэжилтэй. АНУ-д судлаач багш, оюутнуудад лекц уншдаг гэх мэтээр салбартаа чамгүй үнэ хүндтэй байсан тэрбээр Иргэний хөдөлгөөн гэгчийг байгуулж, гудамжинд жагсч, уриа лоозон барьж суусаар Төрийн ордонд орж ирж байлаа. Гэвч төлөөллийнхөө төлөө ажиллаж чадсан уу гэдэгт би биш баянзүрхчүүд дүн тавих биз. МАН-ын нэр дэвшигчийн саналыг хуваах магадлалтай нэгэн эрхэм МАХН-аас нэр дэвшч буй. Тодруулбал, Цэргийн албаны боловсролын доктор, Нобелийн шагналт, НҮБ-ын зэвсгийн шинжээч, хурандаа Д.Эрдэнэцогт энэ тойрогт өрсөлдөж байна. Эзэмшсэн мэргэжил, эрхэлж буй ажилдаа нэртэй төртэй энэ эрхмийг монгол түмэн мэддэг, таньдаг.

Тэр ч утгаараа хоёр намын нэр дэвшигчдийн саналыг хуваах магадлал тун өндөр. Монгол Улсын гавьяат эмч, академич, элэгний гэх тодотголтой М.Шагдарсүрэн энэ тойрогт ТТ эв нэгдлийн эвслээс нэр дэвшлээ. Сонгох, сонгогдох эрхээ эдэлж буй түүний талаар илүү тодорхойлолт хэрэггүй биз. Амьдрал, туулсан замнал нь ард түмний нүдэнд илхэн учраас итгэл үзүүлэх эсэхээ баянзүрхчүүд шийдэх нь. 54 дүгээр тойрогт МАН-аас "Монгол тулгатаны 100 эрхэм" нэвтрүүлгийн хөтлөгч П.Анужин, АН-аас УИХ-ын гишүүн Д.Арвин нарын бүсгүйчүүд тулжээ. Тэд адилхан эмэгтэйчүүд. Нэг нь илүү, нөгөө нь дутуу гэж үнэлэх нь энэ удаад илүүц харагдана. Хоёулаа л өөр өөрийнхөөрөө улс төр, нийгмийн бусад салбарт танигдсан. Хэнийг сонгох нь сонгогч таны эрх. Харин МАХН-аас Монгол Улсын Төрийн соёрхолт гавьяат жүжигчин, урлаг судлалын докторант Ц.Төмөрбаатар, ХҮН-аас намын дарга С.Боргил бие даан нэр дэвшч буй бол, ТТ эв нэгдлийн эвслээс Аюулгүй байдал судлаач Б.Чулуунбат нэр дэвшчээ. Мөн энэ тойрогт эх орон, элгэн түмнээ гэх сэтгэл өвөртөлж яваа монголын шинэ үеийн залуусын төлөөлөл болсон МУГЖ С.Жавхлан нэр дэвшчээ. Өмнө хэлсэнчлэн тэд өөр өөрийн хэмжээнд үнэлэмжтэй хүмүүс. Харин хэнийг төр түшүүлэх вэ гэдгээ 54 дүгээр тойргийн сонгогчид мэдэх билээ. Эндээс харахад Баянзүрх дүүрэг ёстой л набор шиг харагдаж байна. Нийгмийн бүх салбарын төлөөлөл, цаашлаад энд тэндэхийн тойргоос гологдож шилэгдсэн хүмүүс ч цөөнгүй байх аж. Нөгөө талаар үнэхээр сонгочих юмсан, энэ төрд хэрэгтэй шүү гэж үнэлэх лидер улстөрч, лидер эмэгтэйчүүд энэ тойрогт чамгүй олон иржээ. Мэргэн сонголт хийж, төлөөллөө зөв сонгох эсэх нь баянзүрхчүүдийн шийдэх асуудал болж үлдлээ.

Дугаарын **60** мөр

## Хүүхдүүдээ сайхан баярлуулаарай, гэхдээ...

**Үргэлжлэл.**
**Түрүүч нь I нүүрт**

Энэ үеэр 1000 хүүхдийн парад алхаж, баярлахаар цугласан хүүхдүүдэд баярын мэнд хүргэхээс гадна хүүхдүүдийн бүтээлийн үзэсгэлэн, сургуулийн үдийн цай, цэцэрлэгийн хүүхдүүдийн хоолны амталгаат худалдааг ч зохион байгуулах юм билээ. Түүнчлэн өмнөх жилүүдийн баяраас онцлог болгож буй нэг зүйл нь "Монгол наадам цогцолбор"-т өсвөрийн үндэсний бөхийн барилдаан, сур харвааны тэмцээн, "Монгол хүү" өдөрлөгийн нэрэмжит өсвөрийн унадаг дугуйн аварга шалгаруулах тэмцээн, "Миний мэдэх Монгол наадам" гар зургийн уралдаан, хүүхдийн дууны уралдаан ч болох юм билээ. Мөн "Аав, ээж би" гэр бүлийн мини сагсан бөмбөгийн тэмцээн, хүүхэлдэйн киноны баатрын дүрд хэн сайн хувирах вэ зэрэг үйл ажиллагааг ч зохион байгуулах аж. Хэрвээ гэрээсээ хол явж, бяцхан үрсээ баярлуулж амжихгүй гэвэл дүүргүүд ч хүүхдийн баярыг өөр өөрсдийн талбайд тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулна. Тиймээс гэртэй хамгийн ойр газар очиж баярлах бүрэн боломжтой. Энэ мэтээр Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн баяр өргөн дэлгэр сайхан болох нь дамжиггүй. Гэхдээ баярлаж, хөөрч явахдаа хог тарьж, орчноо бууртаглахгүй байгаасай. Мөн хүүхэд төөрч, гэмтэж бэртэхээс ч болгоомжлох ёстойг мартах учиргүй юм. Хүүхдүүдээ жилд ганц тохиох баярынх нь өдөр сэтгэлд нь хүртэл баярлуулах нь зүйн хэрэг. Гэвч энэ өдөр хүүхдийнхээ эрх зөрчигдөж байгаа асуудлыг дорвитой ярьж чадахгүй байна. Тухайлбал, наснаасаа эрт хүнд хөдөлмөр эрхлэх, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх, зарцлагдах зэргээр олон байдлаар хүүхдийн эрх нь зөрчигдөж байгаа. Уг нь Хүүх-дийн эрхийг хамгаалах тухай хуульд хүүхэд эрүүл мэнд өсч бойжих, аюулгүй орчинд амьдрах, хүчирхийллээс ангид байх эрхтэй гэж заасан. Хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байр, ахуйн хэрэгслээр санаатай гачигдуулах, эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсээр хангахыг хориглоно зэрэг заалт ч олон байдаг. Гэвч хүүхдүүдийн хэдэн хувь нь энэ эрхийг эдэлж, аюулгүй таатай орчинд сурч боловсрон амьдарч байгаа нь тодорхой бус. Бидний нэрлэж заншсанаар боломжтой гэх тодотголтой айл өрхийн хүүхдүүд л эрхээ эдэлж амьдарч байна. Харин энэ нийгэмд боломжтой айлаас боломжгүй айл өрхийн тоо хэд дахин ихэсч хүүхдээ тэжээн тэтгэх нь байтугай өөрсдийгөө тэжээлгэх хандлага олширч эхэллээ. Тиймээс баярын өдөр нь зөвхөн баярлуулаад өнгөрөх бус тэдний эрхийг хэрхэн хамгаалах талаар хууль эрх зүйн орчноо эргэн харж, хэрхэн сайжруулах талаар томчууд буюу хүүхдийн гэх тодотголтой байгууллагууд илүүтэй дуугарах хэрэгтэй байгаа юм. Сүүлийн жилүүдэд хүүхдийн амь насыг бүрэлгэх, хүчиндэх зэрэг байж боломгүй гаж үзэгдлийг байдаг л юм шиг хүлээн авах болсон нь харамсалтай. Өөрөөр хэлбэл, нийгмийн сэтгэлзүй цочирдож, сэрдхийсэн байдлаар хүлээн авахаа больчихоод байна. Гэмт хэрэг гарч л байдаг, мэдээлж л байдаг гэсэн байдлаар хан-даж байгаа. Тиймээс хэрхэн сэрэмжлэх тухай асуудлыг ч давхар ярих цаг болжээ. Хүүхдийг хамгаалахдаа төр засаг, байгууллага, эцэг эхийн зүгээс тавих анхаарал халамжийг дээд цэгт хүргэх нь чухал байна.

ЧУХАЛ ХҮН

# Н.МӨНХДАШ: ДАРХАНЫГ ХОЁР ДАХЬ Н ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙГ АН

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

*"Чухал хүн" булангийн маань энэ удаагийн зочноор Дархан-Уул аймгийн Ардчилсан намын дарга Н.Мөнхдаш уригдлаа.*



**-Дархан-Уул аймгийн Ардчилсан намын дарга УИХ-ын сонгуульд нэр дэвших боллоо гэх мэдээлэл бусдаас ялгарч сонсогдлоо. Өөрөөр хэлбэл, намын томилгоогоор сонгогч олонтой уулзаж байгаа кадр биш гэдгээрээ та тэднээс ялгаатай.**

-Магадгүй, тийм байх. "Найрамдал"-аар овоглосон Дархан хот бол миний төрж, өссөн нутаг. Угсаа гарвалаа хөөх аваас аав минь Хэнтий аймгийн Дадал сумын уугуул, ижий минь Говь-Алтайн Тонхил сумынх. Баруун, зүүн аймгийн хоёр залуу МХЗЭ-ийн илгээлтээр Дархан хотод ирж суурьшсан. Ер нь манай Дарханыхан чинь бүгд л илгээлтийн ээзд шүү дээ. Түмэнд өгөөжөө өгсөн сайхан нутаг. Нөгөөтэйгүүр, би таны хэлсэнчлэн гаднаас аль нэг намын томилгоогоор ирээгүй. Дарханчуудын жаргал, зовлонг би мэдэхгүй юм бол хэн мэдэх билээ. Шинэ, хуучин Дарханд миний хөлийн мөр гараагүй нэг ч булан тохой байхгүй. Ардчилсан намын даргаар томилогдсон тэр өдрөөс өнөөдрийг хүртэл дарханчуудынхаа дунд байж, Монгол Улсын хоёр дахь хот гэсэн статусаа хадгалж үлдэхийн төлөө дарханчууд юу хийх ёстойг хамтдаа эрэлхийллээ. Хариуг ч, хөгжлийн гарцаа ч хамтдаа тодорхойлж чадсан гэж хэлж болно.

**-Том өрсөлдөөнд орох гэж байна. Сэтгэлзүйн хувьд өөрийгөө хэр бэлтгэсэн гэж бодож байна?**

-Дархан хот бол Улаанбаатарын дараа орох, Монгол Улсын хоёр дахь нийслэл. Үйлдвэр дагасан том хот. Би энэ хотын нийгэм, эдийн засаг, улс төрийн тогоонд үндсэндээ сүүлийн 12 жил чанагдаж явна. Өөрөөр хэлбэл, 2004 оноос хойш. Энэ утгаараа өөрийгөө Дархан хотын өнгөрсөн түүх, одоо үе, ирээдүй цагтай амьдралаараа холбогдсон хүн гэж ойлгодог. Иргэдийн ажил, амьдралын халуун цөм дотор, энэ нийгмийн болж байгаа, болохгүй доголдож байгаа бүх асуудлуудын дунд орж, хүмүүсийн дотор ажиллаж амьдарч яваа хүний хувьд өөрийгөө бодлого боловсруулагчийн түвшинд хангалттай бэлтгэгдсэн гэж бодож байна. Тиймээс явж ирсэн амьдралын зам, ажлын дадлага туршлага, нас, эзэмшсэн боловсрол аль аль талаасаа цэгнэж үзээд гаргасан шийдвэр юм.

**-Дархан хотыг өнөөдөр хэн бүрдүүлж байгаа нь сонин байна. Тал талаас ирсэн нүүдэлчид үү. Уугуул иргэд нь өнөөдөр хэдэн нас хүрч байна вэ?**

-Дархан хот өнөөдөр 55 нас хүрч буй. 55 жил гэдэг хүний амьдралын нэг жарны түүх. Миний төрж өссөн нутаг минь интернационал хот шүү дээ. Анх оросуудтай хамтарч, үндсэндээ ах нарын хүчээр барьж, байгуулсан юм. Дархан бол Монгол Улсын хүнд болоод хөнгөн үйлдвэрийн салбарыг нуруундаа үүрч яваа хот. Монголын бүх аймгуудаас залуус ирж суурьшиж байсан. Харин унаган хүүхдүүд нь өнөөдөр 55 нас хүрч байгаа. Тэд бол жинхэнэ нутгийн уугуул иргэд. Би ч тэдний нэг нь. Аливаа нэгэн хот өөрийн үүсэл хөгжил, үүх түүх бүх асуудлаа өөрөө тээж явдаг. Түүнийгээ цааш нь хэрхэн, яаж авч явах вэ гэдэг нь тухайн орон нутгийн удирдлага, бодлогыг хэрэгжүүлж байгаа тэр хүрээний улстөрчдийн сэтгэлгээ, тэр нь төрийн түвшинд хэр хүрч байна гэдгээс шалтгаалдаг юм шиг байгаа юм. Дархан бол өнөөдөр үйлдвэр дагасан хот яах аргагүй мөн. Өнөөдөр дарханчууд өөрт заясан баялаг дээрээ тулгуурлаж амьдралаа авч яваа.

**-Баялгийнх нь нөөц харин хэдий хэмжээтэй юм бол?**

-Дархан-Уул бол байгалийн, тэр дундаа барилгын материалын асар их нөөцтэй аймаг. Манай Бурхантын урд хөндий тэр чигээрээ барилгын материалын түүхий эдийн бассейн шүү дээ. Нөөц баялгаар нь аваад үзвэл Дархан асар ирээдүйтэй хот. Яах вэ, барилгын материалын зарим үйлдвэрүүд нь өнөөдрийн зах зээлийн нийгэмд хуучин механизмаараа ажиллаад туйлдаж байгаа нь үнэн. Алдагдалтай, борлуулалтын хэмжээ нь багасчихсан явж байгаа ч би ганцхан зүйлд итгэдэг. Дархан хот цаашдаа Монгол Улсын аж үйлдвэрийн гол цөм хот болно. Ирээдүй нь энэ юм. Тийм учраас би Дархан хотынхоо ирээдүйг үргэлж гэрэл гэгээтэйгээр бодож явдаг.

**-Үнэндээ Дархан хот Монгол Улсын хөгжлийн төв зангилаа гэж би хувьдаа боддог. Барилгын материалаа үйлдвэрлээд Улаанбаатар, Эрдэнэт гэсэн хоёр том зах зээлд нийлүүлэхэд л болоод явчих юм шиг санагдах юм. Та надтай санал нийлэх үү?**

-Тантай санал нийлнэ. Өнөөдөр би Дархан хотынхоо хөгжлийг яг эндээс л харж байгаа. Гэхдээ хөгжил судалгаагүйгээр урагшлахгүй шүү дээ. Дархан хотоос төрсөн эрдэмтэн мэргэдтэйгээ нийлж байгаад "Судалгаа хөгжлийн эрдмийн академи"-ийг байгуулж, Дархан хотынхоо хөгжлийн гарцыг тодорхойлсон. Үнэндээ манай аймаг Монгол Улсдаа хөгжлөөрөө хоцорч явааг нуугаад яах вэ. Увс, Хэнтий, Орхон, Сүхбаатар аймаг бидний нүдэн дээр л хөгжөөд байна шүү дээ. Гэтэл манайх арваад жилийн өмнө ямар байсан тэр хэвээрээ л байгаад байна. Хувь хүмүүсийн барьсан хэдэн барилгыг эс тооцвол бусдын харааг булаах зүйлээр маруухан гэх үү дээ. Улаанбаатар хот болон бусад аймаг, сум, дүүрэгт "Гудамж" төсөл хэрэгжиж, хотынхоо өнгө төрхийг өөрчлөөд л байх юм. Гэтэл манай аймаг, миний хот тэр бүхнээс хоцорчихдог. Манайхаас УИХ-д дэвшсэн түшээд нь ч хөдлөхгүй суусаар дөрвөн жилийг ардаа орхилоо. Энэ бүхнийг зүгээр л хараад, бусдын хөгжилд атаархаж сууна гэдэг хэн хүний тэвчээрийг барах юм байна шүү дээ. Тиймээс өнгөрсөн оны сүүлээр Дархан хотын Ардчилсан нам ээлжит бус их хурлаа зарлаж, "Дархан хотыг эдийн засгийн чөлөөт бүс болгох" тухай асуудлаар гишүүдийнхээ санал бодлыг сонсч, хөтөлбөр боловсруулан Ардчилсан намд хүргүүлсэн. Намын удирдлагууд ч баяртайгаар хүлээн авч, өндөр ач холбогдол өгч буйгаа илэрхийлсэн. Бидний тухайд эдийн засгийн чөлөөт бүс гэхээр заавал яагаад Сайншанд, Алтанбулагт төвлөрөх ёстой гэж. Үнэнийг хэлэхэд, Алтанбулаг бол баг, Сайншанд бол тосгоны статустай. Ийм газрыг манай аймагтай дүйцүүлж яаж болох билээ. Зуу илүү мянган хүн амтай дээр хүнд, хөнгөн үйлдвэрийн бааз суурь нь байна. Өнөөдөр манайд 78 мянган ажлын байр хэрэгтэй байгаа. Ажил хайж буй иргэдийн 35 хувь нь дээд болон тусгай дунд боловсролтой, мэргэшсэн боловсон хүчин байх жишээтэй. Энэ бол ажиллах хүчний хувьд алдаж болохгүй боломж. Үүнийг Монголын төр ашиглах ёстой. Тэгээд ч Монгол Улсын хоёр дахь нийслэл гэдгийг бодлогоор гаргаж ирэх цаг болжээ. Агаарын тээврийг ч хөгжүүлж болно. Талбай нь хангалттай. Хятад, АНУ бодлогоор Шанхай, Нью-Йорк хотоо хоёр дахь нийслэл гэсэн утгаар нь хөгжүүлж ирсэн туршлагыг бид нэвтрүүлмээр байгаа юм. Монголын залуучуудын дийлэнх, манай Дарханы ихэнх нь ЕБС-иа төгсөөд Солонгос эвсэл Европын аль нэг оронд ажиллана гэж мөрөөддөг. Энэ бол монгол залуучуудын ирээдүй биш. Бид ирээдүйгээ өөрөөр төсөөлж харах хэрэгтэй байна. Тийм орчныг нь төрийн түшээд бүрдүүлэхийн төлөө ажиллах учиртай. Сонгуулийн үеэр сайхан зүйл амлаж, сонгогчдын саналыг авчихаад хэргээ бүтээсэн л бол одоо хамаагүй гэсэн шиг шилээ харуулж болохгүй биз дээ. Өнөөдөр дарханчууд хэрхэн яаж амьдарч байна гэж та бодож байна. Эрчүүд нь хаана барилгын халтуурын ажил байна, тэнд. Эмэгтэйчүүд нь бирж хавиар эргэлдэж, хоногийн хоолоо залгуулдаг. Төр болоод төсвийн хэдэн байгууллагад алба хашдаг цөөхөн хүний л амьдрал баталгаатай бусдынх нь тухайд эргэлзээтэй нөхцөлд аж төрдөг. Тиймээс бидэнд зүгээр суух, бусдын аманд хөтлөгдөж явах арга алга.

...Монголын залуучуудын дийлэнх, манай Дарханы ихэнх нь ЕБС-иа төгсөөд Солонгос эвсэл Европын аль нэг оронд ажиллана гэж мөрөөддөг. Энэ бол монгол залуучуудын ирээдүй биш. Бид ирээдүйгээ өөрөөр төсөөлж харах хэрэгтэй байна. Тийм орчныг нь төрийн түшээд бүрдүүлэхийн төлөө ажиллах учиртай. Сонгуулийн үеэр сайхан зүйл амлаж, сонгогчдын саналыг авчихаад хэргээ бүтээсэн л бол одоо хамаагүй гэсэн шиг шилээ харуулж болохгүй биз дээ...

**-Та бизнесмэн хүн. Тэр хэрээр дарханчуудад ямар боломж байгааг ажиглаж явдаг нь мэдээж. Танд ямар боломжууд харагдаж байна?**

-Би аливаа зүйлийг жижгээр харах дургүй. Жижиг сэтгэвэл жижиг л амжилт ирнэ. Том сэтгэж, том харах хэрэгтэй. Өнөөдөр дэлхийн олон улс Европын холбооны улсын эдийн засгийн хориг дор аж төрж байгааг та бүхэн мэдэж байгаа. Тиймээс монголчууд энэ

ӨӨР ӨНЦӨГ

## "САЙН ЭЭЖ" БАЙСНЫХ НЬ ТӨЛӨӨ ШИЙТГЭСЭЭР Л БАЙХ УУ

Ц.ОЮУНТУНГАЛАГ

Ерөнхий сайд асан Н.Алтанхуяг "Ард түмний амьдрал муудаагүй" хэмээн сөрөг хүчнийхэнтэйгээ байнга цэц булаалддаг байв. Гэтэл гэр хороололд талхаа таллаж, худалдан авч байгаа тухай мэдээллүүд ар араасаа хөврөх болсон. Өнөөх "Өндөг бол тансаг хэрэглээ" гэж мэдэгдсэн Н.Алтанхуяг Ерөнхий сайд маань ч удалгүй суудлаасаа буухдаа тулав. "Нэгдүгээрт эдийн засаг, хоёрдугаарт эдийн засаг, гуравдугаарт эдийн засаг" гэж сүржин мэдэгдэл хийсээр Шийдлийн Засгийн газрын тэргүүн Ч.Сайханбилэг гарч ирсэн ч иргэдийн амьдрал сайжирсангүй. Гэтэл Статистикийн газраас ядуурал, ажилгүйдлийн түвшин өмнөхөөсөө дордоогүй гэх хачирхалтай судалгаа танилцуулж олны чихийг дэлдийлгэсэн удаатай. Ийнхүү улс төрөөс хараат бодит мэдээлэл гаргах учиртай Статистикийн газар нь эрх баригчдаа хаацайлсан судалгаа гаргасанд бухимдсан гишүүд цөөнгүй бий. Бодит байдал дээр АН-ын эрх мэдэлд ойр цөөн хэдэн хүний амьдрал сайжирч, үлдсэнийх нь улам муудсан нь нүднээ илт байна. Тодруулбал, Монгол Улсын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өнгөрсөн дөрвөн жилд тасралтгүй унаж, хасах руугаа шилжиж байгаа гэсэн мэдээлэл байна. Улсын нэгдсэн төсөв гэхэд сүүлийн гурван жилд дараалан нэг их наяд гаруй төгрөгөөр тасарч, зарлага санхүүжилтийг цаг тухайд хийж чадахгүйд хүрсэн. 2011 онд 4.6 тэрбум ам.долларт хүрч байсан гадаадын шууд хөрөнгө оруулалт дөрөвхөн жилийн дотор 25 дахин буурч, 182 сая ам.доллар боллоо. 2012 оноос хойш төгрөгийн ханш 50 гаруй хувиар унаж, төгрөг үнэгүйдлээ. Дээр Монгол Улсын гадаад өрийн асуудал иргэн бүрийн сэтгэлийг зовоож байна. Монгол Улсын нийт гадаад өр 21.6 тэрбум ам.долларт хүрч дөнгөж төрсөн нярайгаас өтгөс буурал хүртэл хүн бүр 15 сая төгрөгийн өртэй боллоо. Энэ тоо өдөр ирэх тутам нэмэгдсээр байна гэхээр айдас, жихүүдэс төрмөөр. Улс орны хэмжээнд нөхцөл байдал иймэрхүү гундуу төрхтэй байна. Монголын жирийн айл өрхийн хувьд ч цалин, тэтгэвэр, малчны зээл аваагүй хүнтэй бараг л таарахгүй болов уу. Цалингаас цалингийн хооронд бор хоног, шар өдрүүдийг туулж буй нь үнэн. Хэдий болтол эрх баригчид бодит үнэнийг ард түмнээс нуух гэж оролдох юм бүү мэд. Олон улсын аз жаргалын индекс, зээлжих зэрэглэлээр Монгол Улс ухарч байгаа нь эрх баригчдын "Амьдрал сайхан байна" гэх үгийг худлаа гэдгийг бэлхнээ баталж байгаа. Ер нь Улаанбаатарын захын худалдааны төвд очоод худалдан авалт хийж, байгаа иргэдтэй уулзахад амьдрал ямар байгааг нь тодхон харж болмоор. Энэ оны дэлхийн аз жаргалын индекст Монгол Улс 101 дүгээр байрт жагсчээ. Харин бөмбөрцгийн хамгийн аз жаргалтай улсаар дахиад л Дани Улс шалгарчээ. Тус улс өмнө нь гурван удаа аз жаргалтай улсаар тодорч байсан туршлагатай. Нэг удаа Швейцарьт аз жаргалын индексийн тэргүүн байраа алдсан түүхтэй. Гэтэл Монгол Улс эхний 100-д багтаж чадахгүй, сүүл мушгисаар байна. Энэхүү индексийн хамгийн сүүлд улс төрийн хямрал нь даамжирсан, бослого хөдөлгөөн идэвхижсэн, эдийн засгийн гол үзүүлэлтүүд муудаж, гэмт хэргийн гаралт өссөн улсууд ордог ажээ. Энэ оны жагсаалтад Бурунди, Сири, Того, Афганистан зэрэг улс сүүл мушгисан байна. Монгол эх үрсийн аз жаргалын индекс өмнөх онуудтай харьцуулахад, 35 байраар ухарчээ. Иргэдийн амьдралын чанарын үзүүлэлтээр дөрвөн жилийн өмнө Монгол Улс 192 орноос 72-т явж байсан бол одоо 192-оос 107-д багтжээ. Өөрөөр хэлбэл, Монгол Улсыг эх, хүүхдэд ээлгүй орноор дэлхий нэрлэжээ гэсэн үг. Арга ч үгүй биз. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Монголд устаж үгүй болсон өвчний жагсаалтад багтсан Улаанбурхан дэгдэж 60 гаруй хүүхдийн халуун амыг авч одлоо. Ийм байхад яаж монголыг алаг үрсдээ ачлалтай орноор тодруулах билээ.

Дээр нь хүүхдээ харж байгаа эхчүүдийн нийгмийн баталгааг төрөөс анхаардаггүй. Эмэгтэйчүүд хүүхэд гаргасан л бол ажилгүй, цалингүй, нөхрийнхөө хэтэвч харсан гэр бүлдээ ч эрх мэдэлгүй нэгэн болж хувирдаг нь нууц биш. Эргээд ажилдаа орох гэхээр мэдлэг боловсрол, чадварын хувьд бусдаасаа хоцорсон, нийгмийн даатгал олон жилээр тасалдсан, сэтгэлзүй болоод эдийн засгийн хувьд сайн ээж байснаараа хохирдог гэвэл худлаа ярьсан болохгүй. Монголын төр хэдий болтол хүүхдээ өсгөж бойжуулсан эмэгтэйчүүдээсээ гар татаж, халамжит хань, сайн ээж байсных нь төлөө шийтгэсээр байх вэ. Эмэгтэйчүүдийг хүүхдээ өсгөснийх нь хариуд нийгмийн халамжийн асуудлыг нь шийдээд өгчихдөг төр шиг төр хэрэгтэй байна. Тийм төрийг лав АН өгч чадахгүй юм байна.

ЧУХАЛ ХҮН

# ИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД Н ХЭРЭГЖҮҮЛНЭ



боломжийг ашиглаад дэлхийн брэнд бүтээгдэхүүнүүдийг үйлдвэрлэдэг үйлдвэрүүдээс хоёр, гурвыг ч болов Монголд оруулж ирэхийн төлөө ажилламаар байгаа юм. Хууль эрх зүйн орчныг нь хууль боловсруулагчид анхаарч, татварын таатай нөхцлийг тэдэнд санал болгоход л тэд гүйгээд орно шүү дээ. Дарханчуудын тухайд дээр өгүүлсэн барилгын материалын үйлдвэрүүдийг сэргээх, түүхий эд, материалаа эдийн засгийн эргэлтэдоруулахявдал.Хамгийн хямд өртөг бүхий орон сууцыг манай барилгын компаниуд барьж өгч болно. Хамгийн хямд барилгын материалыг манайд л үйлдвэрлэдэг. Дээр нь төмөрлөгийн үйлдвэр ажилладаг. Миний хувьд санаж, сэдэж яваа бүхнээ ажил хэрэг болгохын төлөө зүтгэж л явна. Өөрийн санал, санаачилгаар Дархан хотод Орон сууц, санхүүжилтийн корпорацийг байгууллаа. Манайд орон сууцны эрэлт их байдаг. Эл асуудлыг бага боловч хүрээнд шийдэх алхам нь ОСК гэж харсан хэрэг. Бас энэ хүрээнд түрээсийн орон сууцны асуудлын эхний хэсгийг өөрийн чадах хэмжээнд шийдлээ. Түрээсийн орон сууцанд 350 иргэн материалаа ирүүлснээс 83 иргэнийг хамрууллаа. Эдгээр иргэд сарын түрээсээ өгөхөөс гадна банкны 30 хувиа хуримтлуулж амжих ёстой. Мөн аймгийн АН-ын зүгээс хэрэгжүүлэх боломжтой гэж харж байгаа зүйл бол иргэдийн зуслангийн газрын асуудал. Түүнчлэн Монгол орны ариун дагшин хөрсөнд ургасан лууванг дэлхийн зах зээлд гаргах, луувангийн зах зээлд хөл тавих боломж бидэнд байна. Завханы улаан сармис гэж байдаг. Хятадууд манайхаас хэдэн арван кг-аар нь авч явдаг. Ааг, амт сайтай сармис. Түүнийг бас ургуулж болно. Хүнсний хамгийн аюулгүй бүтээгдэхүүн манайд л байдаг. Үүнийг мэддэг хятадууд Улаанбаатараас гурил хүртэл зөөдгийг мэдэх үү, зөөдөг юм. Би ч ганц нэг шуудайг аваачиж бэлэглэж байлаа. Бас мах, махан бүтээгдэхүүний экспортын асуудал. Дарханы махны үйлдвэр социалист нийгмийн үед байгуулагдсан тул төрөл бүрээр боловсруулах чадвар, технологи нь байна. Ашиглахгүй л байгаа болохоос биш. Энэ бүхэн алдаж болохгүй бизнес. Тиймээс төрийн бодлого уул уурхай руу биш, ХАА, газар тариалангийн салбарыг дэмжих тал руу чиглэгдэх учиртай. Миний мөрөөдөж явдаг бас нэг зүйл бол Дархан хотыг аялал жуулчлалын төвийн бүс болгох явдал. Дахиад л урд хөршөөр жишээ авъя. Ордос хотыг Хятад улс бодлогоор аялал жуулчлалын бүс болгож хөгжүүлсэн. Өмнө нь тэр газар зүгээр л элсэнд дарагдсан гацаа байсан байхгүй юу. Одоо ямар боллоо. Түүн шиг Монгол Улсын эзэнт гүрэн байсныг түүхийг өгүүлэх цогцолборыг байгуулж, “Их Монгол Улс” хэмээн нэрийднэ. Нөгөөтэйгүүр, аймгийн Ардчилсан нам орон нутгийн ИТХ-д олонхи байсан бол дарханчуудын амьдралд тулгамдаад байсан нийгмийн олон асуудлыг аль эрт шийдчих байсан юм. Гэсэн хэдий ч зургаахан сарын хугацаанд МАН-ын гурван жил хийсэн ажлаас илүүг шийдэж чадсандаа баяртай явдаг.

**-Дарханчууд цэцэрлэг, сургуулийн барилгын асуудлаа шийдчихсэн хэрэг үү. Та энэ талаар дуугарсангүй?**

-Та битгий эмзэглээрэй. Дарханд шинэ сургууль, цэцэрлэг хэрэггүй биш хэрэгтэй. Яг үнэндээ энэ бол жижигхэн асуудал. Монгол Улсын төрийн нэгдсэн бодлогод боловсролын асуудал бүхий л хувилбараар тусгагдсан байгаа шүү дээ. Манай улс хөгжиж дэвшиж байна. Өсвөр үеэ боловсролтой, чадвартай болгож хүмүүжүүлэхийн төлөө бүхнээ зориулж байгаа учраас энэ асуудалд би тэгтлээ санаа зовохгүй байна.

**-Таны улс төрд хөл тавьсан түүхээс сонирхвол?**

-Монгол оронд ардчиллын салхи сэвэлзсэн он жилүүдэд би бага залуу байлаа. Тиймээс болж буй үйл явдлыг эхэндээ залуу хүний сониуч зангаар очиж харна. Яваандаа тэдний хэлж буй үг, баримталж буй бодлого нь чихний үзүүрт сул өнгөрөх дэмий зүйл биш санагдаад явчихсан. Тэгээд л дотоод сэтгэлдээ дэмжиж эхэлсэн. Гагцхүү түүнийгээ ил гаргаж, илэрхийлэх ухаанаа олохгүй хэсэг явсан. Тэр үед би ах нартайгаа ганзагын наймаа эрхэлж, тэднийхээ гарын үзүүрт гүйдэг байв. Ах нар ажлыхаа завсар зайгаар улс төр ярина. Чих тавин чагнасаар аажимдаа нөлөөнд нь автсан. Ингээд 1996 онд Дархан хотын Ардчилсан намд гишүүнээр эхэлсэн. Намайг талийгаач Мөнхбат / манай Дарханых/, М.Сономпил нар гишүүнээр бүртгэн авч байсныг ер мартдаггүй юм. Дараа нь Ерөнхийлөгчийн сонгуульд М.Энхсайхан нэр дэвшиж, өрсөлдөхөд би намын гишүүний хувьд ухуулга сурталчилгааны ажилд нь хувь нэмрээ оруулснаар улс төрд гүнзгий хөл тавьсан гэж хэлж болно.

**-Хоёулаа ярианыхаа сэдвийг жаахан өөрчилье. Хүний амьдралын хамгийн гэгээн тунгалаг үе бол хүүхэд нас. Ингэхэд ямар гэр бүлд өсч хүмүүжсэн талаараа ярихгүй юу?**

-Би сэхээтэн гэр бүлд төрж, өссөн. Аав маань цэргийн хүн, барилгын инженер. Дархан хотод Хээтэй хороолол гэж байдаг даа. Түүнийг аав минь сүндэрлүүлсэн. Дарханчууд аавaар минь бахархдаг юм. Шулуун шударга зантай, ил цагаан үгтэй тийм л эгэлгүй сайхан аавтай байлаа, би.

**-Эцэг эхээс олуулаа юу?**

-Эцэг эхээс тавуулаа. Манайх таван хүүтэй айл. Би бага нь. Дархан хотынхоо IX дунд сургуулийг төгссөн. Хөвгүүдийн нэгэн адил хөлбөмбөг өшиглөөд гарахаараа гэрээ мартдаг Гэсэр явлаа шүү дээ, бага ангидаа. Ангийн дарга ч явж үзлээ. Сахилгагүй хэмээгдэн захирлын өрөөнд ч дуудагдаж үзсэн. Хөвгүүд тийм л байдаг шүү дээ. Харин үеийнхнээсээ түрүүлж, ажил амьдралын мөр хөөсөн. Аравдугаар ангиа төгсөөд ээждээ нэмэр болох гэж хүнсний үйлдвэрт ажилд орж байлаа. Ажиллах хугацаандаа мэргэжилдээ зүрх сэтгэлээсээ хайртай болсон. Жирийн ажилчин байхдаа л 1993 онд “Тэргүүн” гэдэг хувиараа эрхлэх аж ахуйг байгуулж, түүнийгээ өргөтгөн “Тэргүүн трейд” ХХК улмаар “Бурхан халдун” группийг байгуулан ерөнхийлөгчөөр нь ажиллаж байна даа.

**-Та тэгээд хэдийд нь дээд боловсрол эзэмшив?**

-Сурч боловсоръё гэсэн чин хүсэл байхад сурах цаг хугацаа хэзээ ч оройтдоггүй. Би их хожим дээд сургуульд, 2000 онд Хүнсний технологийн коллежид элсч, Исгэлтийн технологич мэргэжлийг эзэмшсэн. Оюутан болохоос өмнө ганц чаддаг зүйл маань энэ байв. Практикаар олж авсан мэргэжил минь гэсэн үг. Дараа нь сургуульдаа магистр хамгаалсан. Удирдлагын академид удирдахуйн ухааны магистр цол ч хамгаалаад амжсан.

**-Хүн өөртөө “Чи эцэг шиг эцэг байж чадсан уу” гэх асуултыг хэзээ нэгэн цагт тавьдаг юм шиг байгаа юм. Та үр хүүхдийнхээ өмнө ямар эцэг вэ?**

-Хэн ч, хэзээ ч асуусан би өөрийгөө сайн эцэг гэж хэлнэ. Надад миний хүүхдүүд толгой өөд татахгүй ном уншсан, өндөр боловсролтой нэгэн байх нь огт хамаагүй. Би түүнийг ерөөсөө нэгдүгээр хэмжүүр гэж үздэггүй. Миний хүүхдүүд харин хэр зэрэг хүнлэг хүн байна вэ гэдэг нь л надад чухал.

**-Их ховор үг байна. Одоогийн эцэг, эхчүүд ямар ч хамаагүй аргаар үр хүүхдээ дэлхийн жишигт дүйцсэн боловсролтой хүн болгоно, болж өгвөл гадаадад сургана л гэж ярих болсон?**

-Би хүүхдүүддээ зүгээр хүн шиг л амьдар гэж хэлдэг. Хүн хорвоо дээр нэг л амьдардаг. Нэг л амьдрахдаа хүн хүндээ хүндлэгдэж, хүний хорвоогийн нэг эд эс болж, хүмүүсийн дунд найз, нөхөртэй явж туулах нь чухал болохоос биш мөнгөтэй байна уу, эд хөрөнгөтэй байна уу гэдэг ерөөсөө чухал асуудал биш. Хүн эхлээд хүн л болох ёстой.

**-Хөрөнгөтэй хүмүүс хүүхдүүдээ бэлэнчлүүлсээр байгаад яс чанарын хувьд нялцгай, тэгсэн атлаа ихээхэн давилуун л нэгэн болгож тавиад байх шиг харагддаг юм. Та хүүхдүүдээ хэр их эрхлүүлдэг вэ?**

-Яг чин сэтгэлээсээ хэлэхэд би хүүхдүүдээ тэгтэл нь эрхлүүлж үзээгүй. Бас араас нь зууралдаад хөөе, хаая энэ тэр гэж хөөцөлддөггүй. Яагаад гэвэл тэр хүн өөрийнхөө амьдралыг өөрөө олох ёстой.

**-Яагаад?**

-Өнөөдөр миний амьдрал болж байгаа нь үнэн. Боломжийг худалдаж авах боломжоог бий болгож чадсан уу гэвэл чадсан. Гэхдээ миний хүүхдүүд өнөөдөр зарим үед хоолны мөнгөгүй, заримдаа таксины мөнгөгүй гээд тусламж хүсдэг л юм. Яагаад гэвэл энэ амьдрал. Би тэр үед хүссэн мөнгийг нь өгдөг. Илүү нэг ч төгрөг өгдөггүй. Заримдаа боддог юм. Хүүхдүүддээ дэндүү хатуу байсан юм биш байгаа гэж. Гэхдээ бэлэнчилнэ гэдэг сайн зүйл биш шүү дээ.

**-Бэлэнчлэлд дургүй гэх атлаа намууд мөнгөн хишиг хүртээсээр ирсэн. Танай нам ч мөн адил?**

-Бэлэнчлэл гэхээсээ илүү нийгмийн давхарга маань ямархуу төвшинд байна вэ гэдгээс л шалтгаалсан амлалтууд. Би зүгээр хэн нэгнийг муулах гэсэнгүй. Ерөнхийдөө иргэд ядуу байх, ингэж харагдах тусмаа ашигтай гэж хараад байгаа юм биш байгаа. Бэлэнчлэл гэдэг зүйл юун дээр цэцэглэн хөгждөг вэ гэвэл ерөөсөө ядуу сэтгэлгээ, нимгэн боловсрол, амьдралын хатуу хөтүү дээр л үүсч байгаа зүйл шүү дээ. Гэхдээ би ядуу юм чинь гээд авах, гуйхаас ичиж нэрэлхэж мэдэхээ байчихсан юм шиг санагддаг. Энэ бол нийгмийг буруу тийш нь залж байгаа явдал юм. Би энэ нийгмийг ийм байдалтай удаан яваасай гэж үнэхээр хүсэхгүй байна. Нийгмийн болоод өрх гэрийн бэлэнчлэл хоёр бол тэс өөр зүйл ч гэлээ, магадгүй өрх гэрийн бэлэнчлэл хүмүүсийг буруу үр дүн рүү түлхэж байна. Харин нийгмийн бэлэнчлэл өөрөө улс орныг буруу хөгжил рүү түлхэж байгааг үгүйсгэхгүй.

**-Улс төрд хөлс хүчээрээ баялаг бүтээж, түүнийхээ үр шимээр хөрөнгөжсөн, төрийн сан хөмрөг рүү гараа дүрээд байхааргүй хүчирхэг бие хүмүүс орж ирээсэй гэх хүсэл сонгогчдод байх шиг байна. Гэхдээ бас нийгмийн зарим хэсэг өмчтэй хүмүүст таагүй хандах гээд байдаг. Энэ талаархи таны бодол?**

-Ер нь төрийн хүн гэж хэн юм бэ. Төрийн хүн гэж Монгол Улсын төлөө бодлого бодож, түүнийгээ хэрэгжүүлж чаддаг хүнийг л хэлнэ. Төрийн хүн бодлого тээгч, бодлого боловсруулагч, бодлого хэрэгжүүлэгч болохоос биш мөнгөтэй, мөнгөгүй байх нь огтоосоо ч хамаагүй. Хамгийн гол нь ард түмнийг зөв голдирол руу залж чаддаг, тэр бодлогынхоо ачаар тэдэндээ хүндлэгдэж явдаг хүнийг л төрийн хүн гэж үнэлэх ёстой.

**-Манай сонгогчид шалдан бодлого хэрэгжүүлэгчийг голж, халаасаасаа мөнгө гаргаад тараах чадал бүхий кадруудад татагдсаар ирлээ шүү дээ?**

-Цаг хугацаагаа бас бод л доо. Бид ардчилсан нийгмийг байгуулах гэж хэдэн жил чадан ядан зүтгэж байна. Нийгмийн шилжилт хэчнээн их эрсдэл дагуулав. Хүмүүс сонгуулиас сонгуулийн хооронд суралцаж, ухаажсаар л ирсэн. Энэ явц салхинд хөөгдсөн юм шиг цэвэрлэгдчихгүй шүү дээ. Улстөрчид нь өөрсдөө иргэдийнхээ сэтгэлд торох бодлогыг явуулах ёстой. Дээр нь манай эрх зүйн тогтолцооны гажуудал асар их гай болж байна. Өнөөдрийн сонгуулийн тухай хуулийг би ярьмаар байна. Энэ бол худалдах, худалдан авах тухай л хууль. Хуулийн логик нь тийм. “Чи намайг сонго. Би чамд өгье. Би чамд өгсөн бол, чи намайг сонго”. Энэ өөрөө буруу тогтолцоо байхгүй юу. Зөв зүйл рүү явъя гэвэл эдийн засгийн хөгжлийн механизмыг хөдөлгөх эрх зүйн тогтолцоо руу орох ёстой. Баялгийг яаж бүтээх вэ, баялгийг яаж өсгөж үржүүлэх вэ гэдэг асуудал чухал болохоос баялгийг гаргаад идэж уухдаа гол биш шүү дээ. Бид маш хурдан худалдагч, худалдан авагч системээс гараад пропорциональ сонгуулийн хэлбэр рүү орвол энэ гажиг тогтолцоо алга болно. Тэгвэл иргэдийн боловсрол мөн өөр тийшээ явна. Намын төлөвшил дээр төрийн нуруу ирнэ. Улстөрчийн тухай асуудал гол биш болно. Мөнгөтэй байна уу, мөнгөгүй байна уу огт хамаагүй. Өнөөдөр манай сонгогчид дөрвөн удаагийн сонгуульд оролцсон. Тэр хэмжээгээрээ туршлагажиж байгаа.

**-Та одоо МАН-ын нөлөө бүхий лидертэй өрсөлдөх гэж байна. Түүнээс юугаараа давуу вэ?**

-Би энэ талаар ярихыг хүсэхгүй байна.

**-Би бол таныг эрх чөлөөний үзлийг, ардчиллын үзэл санааг тээгч гэдгээр бахархан харж байна?**

-Ний нуугүй хэлэхэд би хэн нэгнээс давуу байх, илүү гарах гэж, хэн нэгнээс өөрөөр амьдрах гэж хэзээ ч бодож явсангүй. Тийм ч учраас ялангуяа нэр дэвшигчдээс өөрийгөө юугаараа давуу юм гэж дотроо нэгжихгүй байгаа.

**-Яагаад. Та бөөрөнхий хүн юм биш биз?**

-Үгүй. Би өөрийнхөөрөө л байх дуртай. Хүн үргэлж өөрийнхөөрөө л байх ёстой. Хэн нэгнийг дагах, өөртэйгөө харьцуулаад хэрэггүй.

**-Тэгвэл та өөрийнхөөрөө амьдарч чадаж байгаа юу?**

-Би өөрийнхөөрөө л амьдарч ирсэн. Мэдээж амьдрал юм чинь заримдаа өөрийнхөөрөө байж чадахгүй үе гардаг. Энэ бол амьдралд байдаг л зүйл. Гэхдээ хүн яг дотооддоо өөрийнхөөрөө л явах ёстой. Би өөрийнхөөрөө явна гэдэг нь хүмүүстэй үргэлж зөрөлдөж, сөрж явахыг хэлж байгаа юм биш шүү дээ. Миний өөрийн үзлийг хүмүүс хүлээж авч байна уу, үгүй юу гэдгийг би өөрөө мэдэрч чаддаг байх хэрэгтэй. Хэрэв хүлээж авч, дагаж, зөвшөөрч байвал миний үзэл зөв юм байна гэж боддог. Та надаас ямар нэгэн давуу шинж чанар хэлүүлэх гээд байх шиг байна. Би нэг л зүйл хэлье. Миний зам ард түмний дундаас ирсэн зам гэдгээрээ л би бусад нэр дэвшигчдээс ялгаатай байх. Харамсалтай нь өнөөдөр бүх хүнийг цоо шинээр хардаг тийм цаг үе иржээ. Би энэ хоёр хүнээс илүү Дархан хотын хөгжлийг цоо шинээр харж байгаа. Би хэзээ ч популизм хийхгүй, авлига авахгүй. Хэзээ ч зохион байгуулалтгүй ажил хийхгүй. Зорилгынхоо төлөө ягштал явна. Тэр зорилго араасаа үргэлж ард түмний сэтгэлийг дагуулж явах ёстой.

**-Авлига авахгүй гэдэг үг маш омог бардам сонсогдож байна. Та өөрийн гэх өмчөө хэрхэн яаж бий болгосон бэ. Шууд утгаараа ямар арга замаар?**

-Надад овойж оцойсон их хөрөнгө байхгүй. Байгаа нь цэвэр өөрийн хөлс хүчээр, бизнесээрээ бий болгосон юм. “Бурхан халдун” группээ ч ялгаагүй.

**-Та хамгийн сүүлд хэзээ уйлсан бэ. Магадгүй эр хүнд зохимжгүй асуулт байх. Гэхдээ хүн гэдэг сэтгэлийн амьтан шүү дээ?**

-Сонин асуулт байна. Би уйлах дургүй. Багадаа ч уйланхай хүүхэд байгаагүй. Уйлахын тухайд бүх хүн сэтгэлдээ уйлж явдаг гэж би боддог. Ялангуяа эр хүн. Яг үнэнээ хэлье. Би эцгийгээ нас барахад л уйлсан. Надад сэтгэлдээ уйлах үе байдаг. Гадагшаа бол уйлж байснаа мэдэхгүй байна.

**-Та дуулдаг уу. Ганц нэг дуу аялна биз. Хүнд нэг тийм үе байдаг шүү дээ. Нэг сайхан сэтгэл хөнгөрмөөр?**

-Уртаашаа ганцхан дуутай. Гэхдээ сайн дуулж чадахгүй л дээ. Хүн бугшиж явж болохгүй. Би стрессээ тайлдаг. Бөглөрөөд, гуниглаад байвал тайлах ёстой.

**-Аялчих гээд байдаг тэр дуу тань юу вэ?**

-Аавын тухай ганцхан дуутай.

Тийм ээ…. Хүн ийм л сэтгэлийн амьтан. Түүнийг манай редакцид ирэх сургаар миний дотор “За ямар хүн ирэх бол. Бас л нэг зангиа зүүсэн, их зантайхан нөхөр орж ирэх байх даа. Сонины редакци “Бурхан халдун” группын орд харшийг яаж гүйцэх билээ” гэх хөгийн бодол эргэлдэж байсныг нуугаад яах вэ. Уулзалт, ярилцлага өндөрлөсний дараа машинаа хаячихаад салхи залгин алхалмаар... Сэтгэл хөглөгджээ... Уулзмааргүй, уулзаад хагарч, нээгдэж өгдөггүй, хүнээс хол ширээ товшиж цэрвэсэн, ширүүн дарга олон таардаг. Харин энэ удаагийн зочин маань олны дундаас хайгаад байхад таарч өгөхөө больсон мужик зогсч байлаа. Түүнд итгэж болно. Учир нь тэр насан турш итгэл дааж амьдарсан эр хүн байна билээ.

...Ер нь төрийн хүн гэж хэн юм бэ. Төрийн хүн гэж Монгол Улсын төлөө бодлого бодож, түүнийгээ хэрэгжүүлж чаддаг хүнийг л хэлнэ. Төрийн хүн бодлого тээгч, бодлого боловсруулагч, бодлого хэрэгжүүлэгч болохоос биш мөнгөтэй, мөнгөгүй байх нь огтоосоо ч хамаагүй. Хамгийн гол нь ард түмнийг зөв голдирол руу залж чаддаг, тэр бодлогынхоо ачаар тэдэндээ хүндлэгдэж явдаг хүнийг л төрийн хүн гэж үнэлэх ёстой...

# ДЭЛХИЙ

## АНУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД ШИНЭ ХҮЧИН ОРЖ ИРЛЭЭ




Б.ДАВАА

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль ирэх арваннэгдүгээр сард болох билээ. Эдүгээг хүртэл нам доторх сунгаа идэвхтэй өрнөж, Бүгд найрамдах намаас үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нэр дэвших нь нэгэнт тодорхой болоод байгаа бол Ардчилсан намаас нэр дэвшихээр Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, сенатч Берни Сандерс нар өрсөлдөж байгаа юм. Тэгвэл Ерөнхийлөгчийн сонгуульд шинэ хүчний нэр дэвшигч орж ирлээ. Тодруулбал, улстөрийн жижиг хүчин болох Либериал намаас Шинэ Мексик мужийн захирагч асан Гари Жонсон гэгч АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж буйгаа мэдэгдлээ. Бүгд найрамдах намын нэр дэвшигч Доналд Трамп өрсөлдөгчгүй үлдэж, Ерөнхийлөгчийн сонгуульд хүч үзэх нь нэгэнт тодорхой болсон. Харин Ардчилсан нам дотроо хамгийн олон дэмжигчтэй байгаа Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтоны хувьд хувийн емэйл хуудастай холбоотой дуулиан дэгдэсний улмаас сонгогчид сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлэх болсон юм. Яг ийм үед сонгуулийн тулаанд шинэ хүчин гарч ирж байна. Либериал нам "Хамгийн бага засгийн газар, хамгийн том эрх чөлөө" гэсэн уриаг дэвшүүлжээ. Улмаар Флорида мужийн Орландод намын их хурлыг нээж, тус намаас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг сонгосон байна. Гари Жонсоны хувьд нэр хүндтэй бизнесмэн. Үүгээр зогсохгүй өмнө нь Бүгд найрамдах намд харьяалагдаж байсан удаатай. Түүний хувьд Ерөнхийлөгч болбол Орлогын албан татвар, Корпорациудын орлогын албан татварыг халж, татварын хөнгөлөлт үзүүлэхийн зэрэгцээ хүн сурталгүй төрийн үйлчилгээний системд шилжүүлнэ хэмээн амлаж буй. Түүнчлэн, марихуаныг эмчилгээний зориулалтаар ашиглахыг хуулийн хүрээнд зөвшөөрөхийг дэмжиж байгаа юм байна. Жонсон нам нэгтнүүдийнхээ өмнө гарч хэлсэн үгэндээ нэг зүйлийг тодотгосон сурагтай. Тодруулбал, тэрбээр "Би үнэнээ л хэлье. Би худлаа ярьж чаддаггүй" гэсэн аж. Түүнчлэн, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдэд урам хугарсан сонгогчдын өөртөө татаж, удаан хугацаанд жижиг намын байр сууринд байсан Либериал намын нөлөөллийг тэлэх зорилгоор Гари Жонсон энэ удаагийн сонгуульд нэрээ дэвшүүлээд байна. Либериал хүчин сонгуульд орж ирсний дараа явуулсан нэр дэвшигчдийн рейтингийг харуулах хамгийн сүүлийн үеийн санал асуулгаас харахад, Либериал намын нэр дэвшигч 10 хувийн дэмжлэгийг авсан үзүүлэлттэй яваа юм. Нэр дэвшинэ гэдгээ мэдэгдсэн тус намын гишүүн мэдэгдэлдээ үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трампыг шүүмжлээд амжжээ. Трампын хувьд хүчирхийллийг таслан зогсоохын тулд Мексик АНУ-ын хилд том хана босгоно гэх зэргээр олны эгдүүцлийг төрүүлсэн мэдэгдлийг хийж байв. Тэгвэл Жонсон үл хөдлөхийн тэрбумтны хэлсэн үгтэй холбоотойгоор түүнийг "ялгаварлан гадуурхагч" хэмээн тодорхойлсон юм. Дашрамд дурьдахад, ирэх арваннэгдүгээр сард болох сонгуультай холбоотойгоор явуулсан сүүлийн үеийн санал асуулгад оролцогсдын 60 орчим хувь нь Ардчилсан намаас нэр дэвшигч Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас нэр дэвшигч Доналд Трамп нарт тус бүрт нь "хангалтгүй" гэсэн дүн тавьсан байдаг. Ирэх арваннэгдүгээр сарын сонгуульд Гари Жонсон ялалт байгуулах боломж бараг байхгүй. Гэхдээ Трамп, Хиллари нарт хангалтгүй үнэлгээ өгч буй сонгогчдын дэмжлэгийг авч магадгүй байгаа учир сонгуульд санал хуваах зэргээр маш том нөлөөллийг авчирч магадгүй байгаа юм.

### Бан Ги Мүн нэр дэвших үү

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ги Мүний бүрэн эрхийн хугацаа энэ оны сүүлчээр дуусна. НҮБ-ын тэргүүн эл эрхэм бүрэн эрхийнх нь хугацаа дууссаны дараа чухам юу хийх нь олны анхаарлыг татаж буй юм. Тэгвэл түүнийг Өмнөд Солонгос улсын ирэх оны Ерөнхийлөгчийн сонгуульд хүч үзэж магадгүй гэсэн таамгийг орон нутгийн мэдээллийн агентлагууд дэвшүүлээд байна. Учир нь ойрын үед тэрбээр төрөлх нутаг руугаа үе үехэн мордох болсон гэнэ. Өнгөрөгч амралтын өдрүүдэд Чосон гүрний үеийн байшин барилгуудаас бүрдэх Өмнөд Солонгосын нэгэн тосгонд зочилсон байна. Энэ үеэр Уламжлалт соёлыг хамгаалах ажил хариуцсан албаны хүмүүстэй уулзаж, санаа бодлоо солилцжээ. Түүнээс гадна өнгөрсөн долоо хоногт Японд болсон "Их долоо"-ийн уулзалтад оролцсон юм. Ирэх оны арванхоёрдугаар сард болох Хөх ордоны тэргүүний сонгуульд Бан Ги Мүн эрх баригч намаас нэр дэвшиж магадгүй байна. Гэхдээ НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын албаны бүрэн эрхийнх нь хугацаа дуусахад хэдэн сарын хугацаа үлдсэн тул яг одоогийн байдлаар нэр дэвших үгүй нь тодорхой болоогүй байгаа юм.

### Хятад компанийн реклам америкчуудын дургүйг хүргэв



Хятадын "Шанхай Лейшанг косметикс" компани "Qiaobi" угаалгын нунтагийнхаа шинэхэн рекламыг олон нийтийн хүртээл болгоод буй. Гэсэн ч тус реклам сошиал сүлжээнд тавигдсан даруйдаа дэлхий дахинаа дуулиан дэгдээж, ялангуяа америкчуудын дургүйцлийг ихээр төрүүлээд байна. Рекламны талаар онцлон дурьдвал, хятад эмэгтэй рүү ойртон ирэх өнгөт арьст залууг эмэгтэй угаалгын машин руу түлхэж угаатал цагаан арьст ази залуу болон өөрчлөгдөж буй утга агуулга бүхий сурталчилгаа юм. Америкийн мэдээллийн сайтууд ч уг рекламыг арьс ангаар ялгаварлан гадуурхах утга санааг илэрхийлж байна хэмээн шүүмжилж байна. "Youtube" хуудаснаа тавигдсан уг реклам гуравхан өдрийн дотор л гэхэд долоон сая хандалт авчээ. Тэгвэл олны дургүйцлийг төрүүлсэн тус зар сурталчилгаатай холбогдуулан угаалгын нунтаг үйлдвэрлэгч "Шанхай Лейшанг косметикс" компани нийт хэрэглэгчдээсээ уучлалт хүсч, сурталчилгааны агуулга "Ялгаварлан гадуурхах" утгатай байсныг хүлээн зөвшөөрсөн байна. Үүгээр зогсохгүй тус рекламыг олон нийтийн хэрэгслээр цацахыг хориглож, бүх сайтуудаас линкийг нь устгасан ажээ.


## REQUEST FOR EXPRESSIONS OF INTEREST

**MONGOLIA: SMART GOVERNMENT PROJECT**
Credit No.: 5483-MN

The Government of Mongolia (the Client) has received financing from the World Bank toward the cost of the Smart Government Project, and intends to apply part of the proceeds for consulting services.

The Smart Government development objective is to use ICT to improve accessibility, transparency and efficiency of public services in Mongolia. Thus, under the project, the Cabinet Secretariat of Government of Mongolia is seeking to recruit a qualified staff for the position of Communications Specialist for the Project Implementation Unit (PIU).

**Assignment Title: Communications Specialist**

Under the direct supervision of the Project Coordinator, the Communications Specialist (Consultant) shall be responsible for the day-to-day communications administration of project activities and for the facilitation of the exchange of information between related stakeholders (i.e. the CS, the World Bank, Government agencies, private sector, civil society organizations and citizens) in the project implementation process. The Communications Specialist will work closely with all members of the PIU and make translations from Mongolian to English and English to Mongolian as requested.

**Detailed tasks include, but are not limited to:**

- Provide administrative support to the Project;
- Manage effective collaboration between the Client, the World bank and other related government agencies; and external stakeholders including citizens, private sector and civil society organizations;
- Prepare an external communications plan for the project including: (i) press releases; (ii) media broadcast pieces; (iii) social media strategy for the project;
- Manage the communication of project stakeholders to analyze existing situation of Government of Mongolia (GOM) which could include government operational efficiency, business process re-engineering, IT planning and optimization, systems of systems, service architecture and governance risk and compliance;
- Conduct communications on selected areas with related stakeholders from Cabinet Secretariat and other government organizations as well as with World Bank and Project Implementation unit;
- Present project objectives and outcomes to the stakeholders, GOM and other related organizations;
- Publish web site content and report project progress and achievement;
- Report to, and regularly update the Project Coordinator on progress, problems and constraints of project implementation;
- Support project document translation and provide interpretation services for the PIU;
- Schedule and coordinate meetings, appointments;
- Coordinate incoming and outgoing mail, packages, and deliveries;
- Guide visitors to the PIU;
- Other duties and responsibilities to be requested by the Project Coordinator.

**CONSULTANT'S QUALIFICATIONS/ SELECTION CRITERIA:** Successful applicants will be qualified and experienced to project administrative duties. It is important that the applicant is skilled interpreter and document translator preferably in IT related technical translations and has knowledge and experience of the Government of Mongolia's operations. Previous experience with the World Bank and/or other donors' projects is desirable.

**The Consultant should have:**

- Master degree in Communications, Information System, Information technology, or other related fields;
- At least 10 years of direct relevant experience working on ICT projects, with demonstrable experience on communication and interoperability issues;
- Excellent skills in strategic planning, policy level document development;
- Experience in developing requirements and terms of reference for system applications;
- Experience in communicating and influencing at all levels of an organization from executives to technical IT staff;
- Knowledge and experience with performance analysis related to business process of Government is desirable;
- Knowledge and experience with complex business systems integration and interoperability is desirable;
- Knowledge and experience with World Bank financed projects or other international organizations is desirable;
- Previous experience as a successful administrative duties for government is highly desirable;
- Previous experience with publishing or public relations is highly desirable;
- Additional training or certification in organizational change management highly desirable;
- Fluency in English and Mongolian (listening, reading, writing and speaking);
- Skilled interpreter and document translator in IT related technical translations is desirable;
- High integrity and accountability, good team work spirit

**CONTRACT DURATION AND CONDITIONS:** The assignment is expected to start in July 2016 with a trial period of 6 months. Upon satisfactory performance; the contract will be extended for up to 1 year at a time. The Consultant will be selected in accordance with the World Bank Consultant Guidelines "Guidelines: Selection and Employment of Consultants under IBRD Loans and IDA Credits & Grants by World Bank Borrowers, January 2011"

If you possess the above qualifications, please submit a cover letter indicating why she/he considers her/himself suitable for the position, with detailed CV highlighting skills/experience, copy of diplomas or certificates and two references from two employers no later than **2.00 PM, June 15, 2016. Only those successful candidates will be contacted.** The application documents shall be submitted in person to the below address. The submitted documents will not be returned to the applicants. Incomplete applications would not be considered. If you need any further details, please feel free to contact us.

**Contact address: Ch.Nurgul at the following address: Rooms # 210 and 206; MONTSAME building. B.Jigjidjav street 8, Chingeltei district, Ulaanbaatar. Tel: 329119 and 324699; e-mail: nurgul@smart.gov.mn. All correspondences shall be submitted at Government 11-11 Center. This vacancy notice also can be found at http://cabinet.gov.mn.**



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2016 оны 05 дугаар сарын 30**
Тендер шалгаруулалтын нэр: **"Майкрософт динамикс навижн" системийн 5.0 SP1 хувилбараас 2016 хувилбар луу мэдээллийн бааз сайжруулах ажил**
Тендер шалгаруулалтын дугаар: **12/2016-Н**

МИАТ ХК эрх бүхий тендерт оролцогчдоос Майкрософт динамикс навижн системийн 5.0 SP1 хувилбараас 2016 хувилбар луу мэдээллийн бааз сайжруулах цогц үйлчилгээ үзүүлэх ажлыг гүйцэтгэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь 100000 төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.
Үүнд:
Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн нэг жил 90,000,000 сая төгрөгөөс багагүй байх**
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **90,000,000 төгрөг**
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2015 он**
Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **150,000,000 төгрөг**
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: **Шаардлагатай /Майкрософт Динамикс ERP системийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх албан ёсны эрхтэй байх/**

Тендерийн хамт 2,030,000 төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2016 оны 6 сарын 30-ны өдөр 10 цаг 00 минутаас** өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2016 оны 6 сарын 30-ны өдрийн 10 цаг 30 минутанд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхгүй**
Дотоодны давуу эрх тооцох эсэх: **Тооцно**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**МИАТ ХК, Хан-Уул дүүрэг, 10-р хороо, Буянт-Ухаа дахь МИАТ ТӨХК-ийн төв байр, Захиргаа эрх зүйн хэлтэс, 213 тоот, гэрээ хариуцсан мэргэжилтэн Н.Жадамба**
**Утас: 70049852, 99780000,**
**Факс: 70049919**

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ДООД ХЭМЖЭЭ 516 МЯНГАН ТӨГРӨГ БАЙДАГ

Н.БАТЗАЯА

*Ажилгүйдлийн тэтгэмжтэй холбоотой асуудлын талаарх зарим зүйлийг Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын газрын тэтгэмжийн мэргэжилтэн М.Отгонбаяраас тодруулллаа.*

**- Ажилгүйдлийн тэтгэмжийг ямар тохиолдолд олгодог юм бэ. Энэ талаар тайлбарлаж өгөхгүй юу?**

- Ажилгүйдлийн тэтгэмж нь Олон улсын Хөдөлмөрийн конвенцийн заалтад нийцүүлэн манай улсад 1995 оноос хойш бий болсон. Ажилгүйдлийн даатгалын сангаас 1997 оны нэгдүгээр сарын1-ний өдрөөс ажилгүйдлийн тэтгэмж олгож эхэлсэн байдаг. Нэг үгээр хэлбэл, даатгуулагч ажилгүй болох үед ажилгүйдлийн даатгалын сангаас олгох мөнгөн тусламжийг ажилгүйдлийн тэтгэмж гэж байгаа юм. Жишээлбэл, тухайн даатгуулагч ямар нэгэн шалтгаанаар эрхэлж байсан ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөний улмаас тодорхой хугацаагаар орлогогүй болж, амьдралын баталгаа нь алдагдаж, эрсдэлд ордог. Иймд үед тухайн даатгуулагчийн эрсдлийг бууруулах, дараагийн ажилд орох хүртэл орлоготой болох хүртэл хугацаанд олгодог тэтгэмж гэж ойлгож болно.

**- Ажилгүйдлийн тэтгэмжийг хэрхэн авдаг юм бэ?**

-Энэхүү тэтгэмж нь 1995 онд үүссэн учраас 1995 оноос хойш тооцож олгодог. Мөн тухайн даатгуулагч тушаал гарахаас өмнө сүүлийн есөн сар тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх ёстой. Хэрвээ энэ тохиолдлууд бүрдсэн байвал ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүснэ. Мөн урьд нь ажилгүйдлийн тэтгэмж авч байсан даатгуулагч ажилгүйдлийн даатгалын шимтгэл 12 сар төлсөн нөхцөлд уг тэтгэмжийг дахин авах эрх үүсдэг байгаа.

**-Хэрвээ 1995 оноос өмнө ажилласан жил нь уг тэтгэмжид хамаарахгүй гэсэн үг үү?**

-Тийм. 1995 оноос хойш тооцож олгодог. Учир нь 1995 оноос өмнө ажилгүйдлийн тэтгэмж гэж байгаагүй гэсэн үг.

**- Ажилгүйдлийн тэтгэмжийг хаанаас авах вэ. Ямар материал бүрдүүлэх шаардлагатай вэ?**

-Харьяа дүүргийнхээ нийгмийн даатгалын хэлтэст шаардлагатай материалаа бүрдүүлж өгч, тэтгэмжийн байцаагчаар бодуулна. Ингэхдээ нийгмийн даатгалын дэвтэр, иргэний үнэмлэхээ авч ирэх хэрэгтэй.

**- Ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээ ямар байдаг вэ?**

-Хөдөлмөр нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооноос тогтоосон ажилгүйдлийн тэтгэмжийн доод хэмжээг тогтоосон байдаг. Тэгэхдээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 75 хувиас багагүй байна гэж тогтоосон. Харьяа дүүргийнхээ хэлтэст хандсанаас хойш ажлын 76 хоногийн дотор тэтгэмж нь бодогдож ордог. Энэхүү тэтгэмжийг бодохдоо ажлаас чөлөөлөгдөхийн өмнөх сүүлийн гурван сарын дунджаар 76 өдрөөр бодож олгодог юм.  Доод хэмжээ нь 516 мянган төгрөг байдаг.

**- Ажилгүйдлийн тэтгэмжийг хасч тооцох тохиолдол байдаг уу?**

-Тийм тохиолдлууд байдаг. Уг тэтгэмжийг ажлын 76 өдрөөр бодож олгоно гэсэн хэдий ч тэтгэмжээс ажлын 36 өдрийг хасч олгох нөхцөл бий. Жишээлбэл, тухайн даатгуулагч өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан тохиолдолд энэ нөхцөлөөр хасч бодно. Мөн хөдөлмөрийн сахилгыг удаа дараа буюу ноцтой зөрчсөний улмаас захиргааны санаачилгаар ажлаас халагдсан зэрэг шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн бол ажлын 40 өдрийн тэтгэмж олгодог. Өөрөөр хэлбэл, 36 өдөр нь хасагддаг гэсэн үг.

**-Ажилгүйдлийн тэтгэмж авах гэж буй хүмүүс ихэвчлэн ямар алдаа гаргадаг вэ. Анхааруулж хэлэх зүйлс байдаг байх?**

-Ер нь техник технологи хөгжихийн хэрээр хүмүүсийн мэдээлэл хүлээн авах арга нь нэмэгдсэн байна. Нэг үеэ бодвол хүмүүс харьцангуй мэдээлэл сайтай болсон. Гэхдээ ихэвчлэн хоног хэтэрч нийгмийн даатгалд ханддаг. Уг тэтгэмжийг авахын тулд ажлын 14 хоногт харьяа дүүргийнхээ нийгмийн даатгалд хандах ёстой. Гэтэл хүмүүс хугацаа хэтрүүлж ирээд авч чадахгүй явдаг. Иймл алдаа гаргадаг.

**-Энэ тэтгэмжийн материал бүрдүүлж өгөх хугацааг хойшлуулах тохиолдол байдаггүй юм уу?**

-Тэтгэмжийн материал хүлээж авахад хүндэтгэх хэдэн шалтгааны улмаас хугацааг хойшлуулдаг. Тухайлбал, тухайн байгууллага нь тодорхой шалтгааны улмаас хойшлуулах, амьдарч байгаа нутагт нь хөл хорио тогтоосноос болж хугацаанаасаа хоцорсон, мөн даатгуулагч хүнд өвчилсөн тохиолдолд бол хүндэтгэх шалтгаанд авч үздэг.

**-Хэрвээ даатгуулагчийн харьяалагддаг дүүрэг болон байгууллагынх нь харьяалагддаг дүүрэг өөр байвал аль дүүрэгт нь хандах ёстой вэ?**

-Шилжүүлэг хийнэ. Жишээлбэл, Бат гэдэг хүний ажилладаг байгууллага нь Баянзүрх дүүрэгт шиймтгэл төлдөг. Харин өөрөө Сүхбаатар дүүрэгт амьдардаг гэж бодъё. Иймл тохиолдолд Баянзүрх дүүргээсээ нийгмийн даатгалын дэвтэртээ хасалт хийлгээд Сүхбаатар дүүргийнхээ нийгмийн даатгал руу шилжих ёстой байдаг.

## 18 чиглэлээс Чингисийн талбай хүртэл автобус үнэгүй үйлчилнэ

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн баярын нэгдсэн арга хэмжээ Чингис хааны нэрэмжит талбайд 2016 оны зургадугаар сарын 1-ний өдрийн11:00 цагт эхэлнэ. Энэхүү үйл ажиллагаатай холбоотойгоор хотын захын, харьцангуй хүн амын төвлөрөл ихтэй 18 чиглэлээс Чингисийн талбай хүртэл нийтийн тээврийн үйлчилгээг хүүхэд багачуудаа зориулж үнэгүй явуулахаар боллоо. Тодруулбал , Шархад, Улиастай, Сэлбэ, Жанжин клуб, Баянхошуу, Улаан чулуут, Орбит, Толгойт, Зүүн салаа, Зайсан, Нисэх, Яармаг, Баруунсалаа, Хайлааст, Чингэлтэй, 3,4-р хороолол, таван шар, Офицеруудын ордон гэсэн чиглэлүүдээс нийтийн тээврийн тусгай чиглэлийн автобусууд өглөөний 08:00 цагт хөдөлж Чингисийн талбайд ирэх юм. Мөн орой хаалтын ажиллагааны дараа буюу 17:00 цагаас иргэдийг буцааж хүргэх үйлчилгээг зохион байгуулна. Уг арга хэмжээний үеэр Чингисийн талбайн урд талын “Санктпетрбург”-ийн зогсоолоор хотын зүүн талын Шархад, Улиастай, Сэлбэ, Жанжин клуб, Офицеруудын ордон чиглэлийн таван автобус, “Нийслэлийн Засаг даргын тамгын газрын байр”-ны өмнөх зогсоолоор урд болон баруун талын Зайсан, Нисэх, Яармаг, Баянхошуу, Улаан чулуут, Орбит, Толгойт, Зүүн салаа, таван шар чиглэлийн есөн автобус, зүүн талын “Соёлын төв өргөө”-ний зогсоолоор хойд талын Хайлааст, Чингэлтэй, 3, 4-р хороолол, Баруун салаа чиглэлийн дөрвөн автобус тус тус үйлчилэх юм байна.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Замын хөдөлгөөнд болгоомжтой оролцохыг анхааруулллаа

Замын цагдаагийн газарт энэ сарын 29-нд нийт 267 дуудлага ирсэн байна. Нийт ирсэн дуудлагын 188 нь ослын холбогдолтой дуудлага байгаа аж. Тодруулбал, нэг жолооч, хоёр явган зорчигч согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ замын хөдөлгөөнд оролцжээ. Мөн бага насны гурван хүүхэд бэртэж, гэмтсэн байна. Түүнчлэн жолооч нар согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох тохиолдол ихэсчээ. Өнгөрсөн ням гарагт гэхэд согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 69 тохиолдол бүртгэгдсэн аж. Тиймээс замын цагдаагийн газраас иргэдэд замын хөдөлгөөнд анхаарал болгоомжтой оролцохыг анхааруулллаа.

## Хаврын тариалалт 74 хувьтай үргэлжилж байна

Энэ онд улсын хэмжээгээр 301.5 мянган га-д улаанбуудай, 21.46 мянган га-д үр тарианы төрлийн бусад таримал, 13.4 мянган га-д төмс, 7.1 мянган га-д хүнсний ногоо, 16.3 мянган га-д тэжээлийн, 25.3 мянган га-д тосны ургамал, нийтдээ 385.2 мянган га-д тариалалт хийхээр төлөвлөөд байгаа ажээ. Хаврын тариалалтын бэлтгэл ажил хангагдаж энэ сарын 10-наас тариалалт жигдэрсэн бөгөөд 27-ны өдрийн байдлаар 249 мянган га-д улаанбуудай, 10.9 мянган га-д үр тарианы төрлийн бусад таримал, 8.1 мянган га-д төмс, 2.9 мянган га-д хүнсний ногоо, 1.9 мянган га-д малын тэжээл, 11 мянган га-д тосны ургамал, нийтдээ 283.8 мянган га-д тариалалт хийж 73.7 хувийн явцтай байгаа ажээ.

## ХҮЧИНГҮЙД ТООЦОВ

УХ68061630 регистерийн дугаартай Дагиймаа овогтой Бямбасүрэнгийн 0401691 улсын бүртгэлийн дугаартай Сүхбаатар дүүргийн 19-р хороонд орших 18643328834252 дугаар бүхий газрын гэрчилгээ

Сионий жимс ХХК-ийн 0045326дугаартай НӨАТ-ын гэрчилгээ тус тус гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов

## Тэрбум төгрөгөөр 10 ширхэг түргэн тусламжийн машин худалдаж авна

Эрүүл мэндийн яаралтай, тусламж үйлчилгээгсайжруулахзорилгоорнийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс түргэн тусламжийн 10 машиныг худалдан авах тухай Нийслэлийн Засаг даргын захирамж гарчээ. Өнөөдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд эрүүл мэндийн яаралтай түргэн тусламжийн үйлчилгээнд 70 машин явж байгаа бөгөөд олон улсын стандартаар 8-10 мянган хүн тутамд нэг дуудлагын машин байх ёстой юм. Энэ стандартаар нийслэлийн хэмжээнд яаралтай түргэн тусламжийн үйлчилгээнд 130 машин байвал эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ сайжрах боломжтой юм байна. Тиймээс нийслэлийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор түргэн тусламжийн үйлчилгээнд явах иж бүрэн тоноглогдсон 10 машиныг санхүүгийн болон техникийн чадавх болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан гүйцэтгэгчийг шууд гэрээ байгуулах замаар сонгон шалгаруулан нэг тэрбум гучин сая төгрөгөөр худалдан авахаар боллоо.

## Автомашингүй өдөр энэ сарын 04-нд тохионо

“Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд "Улаанбаатар Марафон 2016" олон улсын гүйлт ирэх сарын 04-ний өдөр Их эзэн Чингис хааны нэрэмжит талбайд болно. Энэ өдрийг “Автомашингүй өдөр” болгож, автомашины хөдөлгөөнийг хязгаарласан зам талбайд спортын талбай байгуулж олон нийтийг хамарсан уралдаан тэмцээн, урлаг соёлын арга хэмжээ, худалдаа үйлчилгээ зохион байгуулах бөгөөд томоохон зах худалдааны төвүүд амрах ажээ. Марафоны 5000 метрийн гүйлт нь Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай - Төв шуудан - Энх тайвны өргөн чөлөө - Цэцэг төв- Зоос гоёл - МУИС – Бээжингийн гудамж-Чингис зочид буудал – Бөхийн өргөө-Энхтайвны өргөн чөлөө – СЭЗИС – МУБИС- Дуурь бүжгийн эрдмийн театр - Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гэсэн маршуртаар гүйх юм. Харин 10000 метрийн гүйлт нь Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай - Төв шуудан - Сөүлийн гудамж -"Норе" шүдний эмнэлэг - Бишрэлт дэлгүүр - Зоос гоёл - 5-р сургууль - Хүүхдийн урлан бүтээх төв - МУИС - ШУТИС-ийн уулзвар - Чингис зочид буудал - Сансарын аюулгүйн тойрог - Баянцээл дэлгүүр - Зүүн 4-н замын уулзвар - Бөхийн өргөө-СЭЗДС-МУБИС-ДБЭТ-Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гэсэн маршуртаар гүйнэ. Энэ өдөр марафон гүйх замууд болон Баруун дөрвөн замаас Зүүн дөрвөн зам хүртэл 08:00-18:00 цагийн хугацаанд автомашингүй бүс байх юм.

PHOTO NEWS



*Цэцэрлэгийн багачууд гамшгаас хамгаалах ажиллагаанд оролцлоо Жил бүр нийслэлийн Засаг даргын захирамжаар гамшгаас хамгаалах сургалт, дадлага уралдаан тэмцээнийг зохион байгуулдаг. Энэ жил цэцэрлэгийн хүүхэд багачуудын дунд “Аюулгүй амьдрах арга ухаанд суралцъя, хэвшүүлье, нөлөөлье” сэдвийн дор гамшгаас хамгаалах сургалт, дадлагыг уралдаант тэмцээний хэлбэрээр зохион байгууллаа. Энэхүү тэмцээнд нийслэлийн есөн дүүргийн цэцэрлэгийн 140 хүүхэд багачууд оролцлоо.*




*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*

ЗАВСАРЛАГА

# БАТБАЙГАЛИЙНХАН

## БАГАЧУУДДАА ИЙМ БЭЛЭГ БАРИЛАА





Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ДАВАА

Аливаа баяр ёслолыг амтат бялуугүйгээр төсөөлөхийн аргагүй. Их ажлын хажуугаар гэр бүл, ах дүү, үр хүүхдийнхээ хамт баярын ширээ тойрон суухад, тэрхүү ширээний амттай чимэг нь бялуу байх нь бий. Тэгвэл бидний баяр дээр баяр, жаргал дээр жаргал нэмэх амтат бялуу, нарийн боовыг үйлдвэрлэн шив шинэхэн, халуунаар нь хэрэглэгчдийн гарт хүргэдэг "Батбайгаль" ХХК олон улсын хүүхдийн баярыг тохиолдуулан "Би бялуунд дуртай" торт чимэглэх уралдааныг хамтран ажилладаг байгууллагуудынхаа бяцхан хэрэглэгчдийнхээ дунд зохион байгууллаа. Тодруулбал, Нийслэлийн Архивын газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Чингэлтэй дүүргийн мэргэжлийн хяналтын хэлтэс, Чингэлтэй дүүргийн Замын цагдаагийн тасаг болон UBS телевизийн ажилтан, албахаагчдын энхрий бяцхан үрс торт чимэглэх уралдаанд идэвхийлэн оролцсон юм. Тэмцээн 5-8, 9-12 гэсэн хоёр насны ангилалаар зохион байгуулагдсан бөгөөд 30 гаруй хүүхэд багачууд оролцон, өөр өөрсдийн уран сэтгэмж, бүтээлч чадвараараа өрсөлдлөө. Тэмцээний эхний үе 5-8 насныхны дунд болж, тогоочийн цагаан малгай өмссөн жаалууд тусгай зассан ширээний ард зогсч, цав цагаан цаас адил тортыг "angry bird" буюу уууртай шувуу урлан чимэглэх даалгаврыг авсан. Батбайгаль ХХК-ийн ажилтнууд хүүхэд нэг бүрт зөвлөгөө өгч, зааж сургаж байсныг энд тэмдэглэх хэрэгтэй болов уу. Өнгө өнгийн бялуу чимэглэх тусгай кремийг ширээн дээр тавьсан байх бөгөөд хүүхэд өөрийн бүтээлч чадвар уран сэтгэмжээрээ уууртай шувууг ямар ч байдлаар дүрсэлж болох ажээ. Ширээний ард зогсоо бяцхан тогоочид ч ямар эгдүүтэй харагдаж байсныг уншигч та төсөөлж буй бизээ. Өөрт ногдсон даалгавраа биелүүлэх хүүхдүүд өөрийн ертөнц дэх хүүхэлдэйн киноны баатраа амтархан идэх дуртай торт дээрээ их л няхуур урлаж байсан юм. Эцэг, эх нь ч хүүхдийнхээ цамцны захыг мушгиж, суудлаасаа өндөлзөж, "миний хүү, охин гоё хийж байна" хэмээн урмыг үгийг хэлж байв. Тэртээ 1996 онд гэр бүлийн дөрвөн хүн нийлж, "Батбайгаль" ХХК-ийн тулгын гурван чулууг тавьж байсан түүхтэй. Тэр үеэс хойш эдүгээ 20 жилийн турш нийслэлчүүдээ амттай, чанартай торт, нарийн боовоор хангаж ирсэн эдний хамт олон тэгш ойнхоо хүрээнд 20 ажлыг зохион байгуулахаар төлөвлөжээ. Улмаар ой угтсан ажлын хүрээнд торт чимэглэх уралдааныг эдүгээ хоёр дахь удаагаа зохион байгуулж байгаа юм байна. Эхний тэмцээн олон улсын эмэгтэйчүүдийн баяраар буюу өнгөрөгч гуравдугаар сарын 8-нд нийт хэрэглэгчдийн дунд зохион байгуулагдаж, фэйсбүүкээр хамгийн олон лайк авсан хэрэглэгч ялагч болж байжээ. Уг үйл ажиллагаанд 40 гаруй гарын ур дүйтэй хэрэглэгчид оролцсон аж. Харин энэ удаа Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан төрийн байгууллагын ажилтан алба хаагчдын хүүхдүүдийн дунд бялуу чимэглэх уралдааныг зохион байгуулж буй нь энэ юм байна. 5-8 настанууд "Уууртай шувуу"-г амттан дээр урлаж байх зуурт авьяаслаг хүүхдүүд урлагийн тоглолт үзүүлж, үзэгчдийг баярлуулж байв.

### Шинэхэн бүтээгдэхүүнээрээ оролцогчдоо дайлав

Эхний насны ангилалын тэмцээн дуусч, хоёр дахь үеийнхэн тэмцээндээ орохын өмнө багахан хэмжээний үдийн цайг тус компанийнхан бэлтгэсэн байв. Шинэхэн, халуухан бүтээгдэхүүн, цэвэр жимсний шүүснүүдийг эгнүүлэн тавьсан байх бөгөөд тэмцээнд оролцсон жаалууд эцэг, эхийнхээ хамт дугаарлан амттай бүтээгдэхүүнийг зооглож үдийн цайгаа уув. Ингэх зуураа тэмцээний сонин сайхнаас хөөрөлдсөн үрс эцэг, эхдээ ам уралдан торт чимэглэхэд тулгарсан бэрхшээл, туршлагаасаа шулганах аж. 20 жилийнхээ ойг угтаад буй "Батбайгаль" ХХК эдүгээ 120 гаруй ажилтантай 18 салбараар үйл ажиллагаагаа явуулж, дээд зэргийн амт найрлагатай 80 нэр төрлийн бялуу, 150 нэр төрлийн нарийн боов, нандин бүтээгдэхүүн, 10 нэр төрлийн пицца болон махан бүтээгдэхүүнийг хэрэглэгчиддээ санал болгож байна. "Аливаа нандин бүтээгдэхүүн, нарийн боов шинэхэн, халуунаараа байх тусмаа амттай чанартай байдаг юм. Эрүүл, аюулгүй хүнсээр хэрэглэгчдээ хангах бидний гол зорилтын нэг" хэмээн тус компанийн захирал С.Байгальмаа манай сонины "Би Монголоо ингэж хөгжүүлнэ" буланд уригдахдаа ярьж байсныг уншигчид санаж байгаа болов уу. Иймээс ч "Хүнсний баталгаат байдлыг хангах" зорилт тавьсан эдний хамт олон хэрэглэгчиддээ ойр байх үүднээс салбаруудаа нээж, хэрэглэгчдийнхээ нүдэн дээр амттай нарийн боовыг хийж, хав халуунаар нь хүргэх ажиллагаанд шилжиж байгаа билээ. Үүнээс гадна үйлдвэртээ Микробиологийн лабораторитай тул Батбайгалийн гайхалтай амттанууд бусад ямар ч амттануудтай адилгүй хэрэглэгчдийнхээ таашаалд бүрэн нийцдэг биз.

> ...Крем нь шингэн болохоор тортыг чимэглэхэд их хэцүү байдаг юм билээ. Өмнө нь тортны чимэглэлийг харахад амархан ч юм шиг харагддаг байсан. Яг өөрөө хийгээд үзэхээр хэцүү юм байна...

### Шилдгүүд тодорлоо

Цайллагын дараа хоёр дахь насны ангилалын тэмцээн эхлэв. Тэдний даалгавар нь үлгэрийн баатар спонж бобыг урлах байсан юм. 9-12 насныхан дэлгэц дээр харуулсан зургийг харж, өөрийн төсөөллөөрөө хөөсөн бобыг урласан бөгөөд гуравхан минутын дотор өгөгдсөн даалгавраа амжилттай дуусгасан нэгэн ч байв. Ингээд хүүхэд бүрийн хүсэн хүлээсэн мөч ирж, шүүгчдийн бүрэлдэхүүн шилдгүүдийг танилцууллаа. Улмаар 5-8 насны ангилалд найман настай С.Солонго охин тэргүүлж, Б.Дөлгөөн охин дэд байрт шалгарсан юм. Харин 9-12 насны ангилалд 11 настай Э.Ану, А.Намуун нарын охид тэргүүн, дэд байрыг эзлэв. Шилдгээр шалгарсан хүүхдүүдийг Батбайгаль компанийн нэрийн бүтээгдэхүүний бүтэн жилийн хэрэглээний эрхийн бичиг, шинэхэн нэрийн бүтээгдэхүүний амттанаас гадна өөрийнх нь чимэглэсэн амтат бялуу дагалдан очиж байсан юм. Түүнчлэн оролцсон бүх хүүхдүүд Батбайгалийн шинэхэн амтат бүтээгдэхүүнээс бүрдэх гарын бэлэг, өөрийн чимэглэсэн тортоо гардаж авлаа. Иймхүү 30 гаруй бяцхан үрс тус компанийнхны сэдэж санаачилсан уралдаант тэмцээнд оролцож, амтат нарийн боов, тортыг амтлан нэгэн үдшийг хэзээ ч мартагдашгүйгээр баярлаж өнгөрүүллээ. Хэнбугай нь ч аз жаргалыг хуваалцах, аз жаргалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч Батбайгалийнхаа хамт олонд тэмцээнд оролцсон 30 гаруй жаалууд, бүтээгдэхүүнийг нь хэрэглэгч зуу зуун хүүхдийнхээ өмнөөс халуун талархал дэвшүүлж, ойн баярын мэнд хүргэе. Ингээд түрүүлсэн хүүхдүүдийн сэтгэгдлийн хуваалцсанаа уншигч танд сонирхуулья.

### Э.Ану: Их гоё, бас хэцүү байлаа



/9-12 насны ангилын тэргүүн байрын шагналт/

-Миний насны ангилалд торт дээр Спонж Бобыг хийх даалгавар өгсөн. Өөрөө ийм орчинд ирээд торт чимэглэж үзлээ. Их гоё, бас хэцүү байлаа. Найзтайгаа хамт оо ашиглан бэлтгэлээ базаасан. Энэ тэмцээнийг зохион байгуулсан Батбайгаль ХХК-ийн ах эгч нартаа маш их баярлалаа. Би болон манай гэр бүлийнхэн Батбайгалийн торт, нарийн боовыг байнга хэрэглэдэг. Тэмцээнд ороод бүтээгдэхүүний бүтэн жилийн хэрэглээний "Эрхийн бичиг"-ээр шагнуулж, өөрийн хийсэн торт хийгээд тус компанийн ах эгч нарийн хийсэн шинэхэн бүтээгдэхүүний дээжээс бүрдсэн амттай бэлэгнүүдийн эзэн болсондоо баяртай байна.

### С.Солонго: Өөрийнхөө чимэглэсэн тортоо гэртээ авч очих гэж буйдаа баяртай байна



/5-8 насны тэргүүн байрын шагналт/

-Би бялуунд дуртай торт чимэглэх тэмцээнд түрүүлсэндээ маш их баяртай байна. Торт чимэглэх амархан санагдсан. Гэртээ цаасан дээр торт зураад, youtube-ээс бичлэг үзэж санаа аваад, өөрийнхөөрөө оо ашиглан торт чимэглэх тэмцээндээ бэлдсэн. Аав ээж минь миний хийсэн зүйлийг хараад гоё байна гэж урамшуулсан. Тэмцээний талаар аавaасаа сонссон өдрөөсөө л бэлтгэлээ хийсэн. "Уууртай шувуу"-г хийх жаахан хэцүү юм байна. "Батбайгаль" ХХК-ийн ах эгч нартаа баярлалаа. Хэрвээ энэ үйл ажиллагааг зохион байгуулаагүй байсан бол бид ингэж гоё амттан чимэглэж, баярлаж чадахгүй байсан болов уу. Өөрийнхөө чимэглэсэн тортоо гэртээ авч очих гэж буйдаа баяртай байна.

### А.Намуун: "Батбайгаль" ХХК–ийнхаа ах эгч нартаа баярлалаа



/9-12 насны дэд байрын шагналт/

-Крем нь шингэн болохоор тортыг чимэглэхэд их хэцүү байдаг юм билээ. Өмнө нь тортны чимэглэлийг харахад амархан ч юм шиг харагддаг байсан. Яг өөрөө хийгээд үзэхээр хэцүү юм байна. Бэлтгэлээ найзтайгаа хамт хангасан. Хамтдаа шүдний оо ашиглаад л түүнийгээ крем гэж төсөөлөн торт чимэглэх бэлтгэлээ хийсэн. Гэртээ аав ээжийнхээ дэргэд гоё чимэглэж чадаж байсан. Энд ирээд маш олон хүний хажууд их сандарсан. Хүүхдийн баярыг тохиолдуулан ийм сайхан тэмцээнийг зохион байгуулж байгаа Батбайгаль ХХК-ийнхаа ах эгч нартаа баярлалаа. Дахиад олон олон тэмцээн уралдааныг зохион байгуулж өгөөрэй.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр +28
Шөнө +11

Нөгөөдөр
Өдөр +28
Шөнө +12

## Өдрийн зурхай

**Аргын тооллын:**
*2016 оны 5-р сарын 31 , Мягмар гараг*

**Билгийн тооллын:**
*Шинийн 25. Есөн улаан мэнгэтэй Харагчин үхэр өдөр*

**Наран ургах/шингэх:**
*05:09 / 20:37*

**Үс засуулбал:**
*Нүд бүрэлзэн улцайна*



Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гэрээ хийх, мал, адгуус муулах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, улааны үйл, хур оруулах, дарханы үйлд сайн. Төлөг тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## Маргааш болох зарим үйл ажиллагаанууд

"Олон улсын хүүхдийн эрхийн өдөр"-ийг манай улс 64 дахь жилдээ тэмдэглэх гэж байна. Энэ жилийн хувьд хүүхдийн баяраар томоохон талбай, үзвэр үйлчилгээний олон байгууллагууд арга хэмжээ зохион байгуулахаар хөтөлбөр гаргажээ. Тус арга хэмжээнүүдийг нэгдсэн байдлаар хүргэж байна.

**"Монгол хүү" үндэсний хүүхдийн баяр**
( Хүй долоон худагт)

**"Шидэт Бонго далайгаар аялсан нь"**
(Монголын Үндэсний циркэд)

**"Мөрөөдлийн Ертөнц-2016" өдөрлөг**
(Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд)

**"1000 хүүхдийн парад"**
(Чингисийн талбайд зургаадугаар сарын 1-нд)

**"Шидэт ойн гүн дэх" аялал**
(Хүннү моллд)

**"Бардам туулай", "Үнсгэлжин", "Норовын намтар" хүүхдийн жүжиг**
(Улсын драмын эрдмийн театрт)

**"Viva children`s day 2016" өдөрлөг**
(Viva city хороололд)

**"Галт чулууны нууц" хүүхдийн жүжиг**
(UB Palace)

**"Achilles KIDs -UB 2016" багачуудын гүйлт**
(Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд)

**"Амьдралын алтан мөчийг Гэгээнтэнд" өдөрлөг**
(Гэгээнтэн энтертайнмент төвд)

**"Цирк ирлээ" Улан-Удэ Монголын циркийн хамтарсан тоглолт**
(Аса циркт)

**"Happy Children's Day" арга хэмжээ**
(Blue Sky)